



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Наранцэцэгийн АЛТАНШАГАЙ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2025. 12. 12 № УУХ-03/14215
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн миний бие нэр бүхий гишүүдийн хамт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ~~...~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.АЛТАНШАГАЙ

Ж.АЛДАРЖАВХЛАН

Н.АЛТАНХУЯГ

О.АЛТАНГЭРЭЛ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР


Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ



М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ


Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР



Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЭН

Э.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ



Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ



С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДУХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН



Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

П.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБААТАР

М.НАРАНТУЯА-НАРА





Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР



С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА



Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН



А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Дав. ЦОГТБААТАР

Дам. ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ



С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Наранцэцэгийн АЛТАНШАГАЙ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2025.12.02 № 4111-03/13767
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов
тогтоолгох тухай

Улсын Их Хурлын гишүүн миний бие нэр бүхий 39 гишүүний хамт Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу тов тогтоолгохоор үүгээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Н.АЛТАНШАГАЙ



000000017



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ НАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.06.06 № ХТ/1640
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Та бүхний санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ⁰¹ ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.УЧРАЛ

200255009710

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“16.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нарын санаачлан боловсруулсан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нарын санаачлан боловсруулсан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцээд, дараах саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:


1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хязгаарт хамаарахгүй байхаар тусгасан нь цаашид төсвийн зардал огцом нэмэгдэж, төсвийн сахилга бат алдагдах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо буурч, төрийн оролцоо нэмэгдэх, макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах зэрэг эрсдэл үүсэхээр байгааг анхаарах.

2.Мөн хуулийн төслийн 5 дугаар зүйлд дээрх төслүүдийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэнээр тухайн жилийн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтэрч болохоор заасан нь улсын өрийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй байх тул Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.13-т ““өрийн хязгаар” гэж Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх дээд хэмжээг хувьчлан тогтоосныг” гэж заасантай уялдуулах.

3.Гадаадын зээлээр хэрэгжиж байгаа төслүүдийн хувьд хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт үүсэхээс сэргийлэх зорилгоор хуулийн төсөлд төслүүдийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллагаас жил бүр хяналт тавих зохицуулалт нэмэх.

Түүнчлэн, тухайн төслийн хүрээнд бий болсон хөрөнгө, барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгчийг тогтоох, тэдгээрийн эрх, үүрэг, өмчийн удирдлага, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах.

4.Хуулийн төсөл нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой томоохон төслүүдийг дэмжих, гадаад зээллэгийн үр ашгийг нэмэгдүүлэх тодорхой зорилготой боловч төсвийн сахилга батыг сайжруулах, хууль зүйн нийцэл, хэрэгжилтийн уян хатан нөхцөлийг хангах чиглэлд анхаарч, зохицуулах харилцааг нэмж тусгах, боловсруулалтыг сайжруулах шаардлагатай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.АЛТАНШАГАЙ

**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих хууль нь 2021 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 3.1-д “Энэ хуулиар Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах болон түүхий тос дамжуулах хоолойн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийг барьж, ашиглалтад оруулах, үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.” гэж заасан ба энэхүү хуулийн дагуу “Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг 2021 онд Засгийн газрын 241 тоот тогтоолоор баталсан байдаг.

Улсын Их Хурлаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-тэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 1.0 тэрбум ам.долларын, 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 700.0 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг тус тус хуулиар соёрхон баталсан. Энэ хүрээнд Засгийн газраас 2017 онд “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тухай” 59 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолын 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэхээр тогтсугай.” гэж заасан байна.

Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталж, тус хэлэлцээрийн хүрээнд “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг 2024 оны 11 дүгээр сард байгуулаад байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдэд дээр дурдсан дэд бүтцийн мега төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 2 дугаар хавсралтын 4.2.16-д "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна" гэж, 4.2.36-д "Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна" гэж, 3.2-т "Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн орон байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ" гэж, 3.2.3-т "Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ.";

2. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал"-ын 1 дүгээр хавсралтын 3.2.4.3-т "Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана" гэж, 3.2.4.2-т "Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана" гэж;

3. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 3 дугаар хавсралт дахь "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 8-д "Эрчим хүчний шинэ эх үүсвэр барих төслүүд /...Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц,/" гэж, 11-д Газрын тос боловсруулах төслүүд /Газрын тосны нөөц хайгуулын төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, дагалдах барилга байгууламжийн төсөл/" гэж;

4. Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын 1 дүгээр хавсралтын 3.6.2-т "Дорноговь аймгийн Алтанширээт суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна" гэж, 3.2.22-т "Ховд аймгийн Ховд гол дээр эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина" гэж;

5. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтад 14 мега төслийн жагсаалтын 3-т "Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ." гэж, мөн жагсаалтын 12-т "Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна." гэж;

6. Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 2 дугаар хавсралт дахь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.4.3.8-д "Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг үргэлжлүүлэх.", 1.7.2.1-д "Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станц барих." гэж тус тус заасан байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ”-г санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газарт олгосон. Үүний дагуу Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ”-г санхүүжүүлэх зориулалтаар 500.0 (таван зуу) хүртэлх сая ам.долларын нийслэлийн гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд 2024 онд багтаан арилжаалахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид зөвшөөрсөн байна.

Иймд, дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах, дэд бүтцийн мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх буюу Гадаад зээллэгийн¹ ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар 1991–2024 онуудад хөгжлийн түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор нийт 21.7 их наяд төгрөгийн гадаад зээлийг авч ашиглаж, нийт 228 төслийг хэрэгжүүлээд байна. Эдгээрийн 156 төсөл нь хэрэгжиж дууссан бөгөөд одоогоор 72 зээлийн төсөл хэрэгжиж байгаа бол хэлэлцээрийн шатанд 17.9 их наяд төгрөгийн 17 төсөл байна.

Монгол Улсад 1990-1999 онуудад нийт 1.3 тэрбум ам.долларын барааны зээл, банк санхүү, жижиг дунд үйлдвэрлэл болон эрүүл мэнд, нийгмийн суурь дэд бүтцийн шинж чанартай, эдийн засгийн шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулах зорилготой зээл зонхилж байв. Харин 2000-2009 онуудад шинэ дэд бүтэц бий болгох, тодруулбал дулааны цахилгаан станцыг шинэчлэх, авто зам болон төмөр зам барих, аймгуудын орон сууц нийтийн аж ахуй болон агаарын тээврийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр нийт 1.5 тэрбум ам.долларын зээлийг авч ашигласан байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд Улаанбаатар хотын суурьшлын бүсийг тэлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй өндөр өртөг бүхий томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гадаад төслийн зээл авч ашигласан ба Япон улсын зээлээр “Шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл”, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээлээр “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны автозам барих төсөл”, Азийн Хөгжлийн банкны зээлээр “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2” зэрэг томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлээд байна.

Дээрх хугацаанд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын

¹ **Тайлбар:** “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

санхүүгийн байгууллагууд болон Япон Улс, БНХАУ, БНСУ, БНЭУ зэрэг хоёр талын хөгжлийн түнш орнуудаас хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг авч, эдийн засаг, нийгэм, дэд бүтэц, хөдөө аж ахуй зэрэг салбарын хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. Нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын төсөвт ирэх шууд ачааллыг бууруулж, дунд болон урт хугацаанд хөгжлийн суурийг тавих чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Түүнчлэн, уул уурхайн салбар дахь гадаадын хувийн хөрөнгө оруулалт болон Монгол Улсын Засгийн газрын олон улсын санхүүгийн зах зээл дээрх гадаад зээллэг нь гадаад санхүүжилтийн зонхилох эх үүсвэр бөгөөд цаашдаа ч Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогыг амжилттай хэрэгжүүлэх, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, зорилтууд, эдийн засгийн өсөлтийг хангах, мега төслүүдийг хэрэгжүүлэхэд чухал эх үүсвэр хэвээр байхаар байна.

2025 оны байдлаар Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан, хэрэгжилтийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа нийт 17.9 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаад зээлийн 72 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 5.3 их наяд төгрөг буюу 29.6 хувийг ашигласан, үлдсэн 12.6 их наяд төгрөг буюу 70.4 хувь нь одоогоор ашиглагдаагүй, үүнээс 2025 онд 1.5 их наяд төгрөгийг ашиглахаар 2025 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Эдгээр төслүүдийн 82 хувь нь 2025-2028 онд хэрэгжиж дуусахаар гэрээ, хэлэлцээртэй байгаа нь гэрээний хугацаанд санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлж, төслүүдийг ашиглалтад оруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төслөөс дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах өндөр ач холбогдол бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангаж жилд дунджаар 30.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл” болон иргэдийг орон сууцжуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон үүрэгтэй “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд санхүүжилтийг ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах дараах практик шаардлагууд тулгамдаж байна. Үүнд:

1. Гадаад төслийн зээлийн нийт ашиглагдаагүй үлдэгдэл одоогийн байдлаар 12.6 их наяд төгрөг буюу үүний 53 хувь буюу 6.7 их наяд төгрөг нь Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих мега төслүүдийн санхүүжилт байна. Гадаад төслийн зээлийн ашиглалтыг 2025 оны түвшнөөр буюу дунджаар 1.5 их наяд төгрөг байхаар тооцвол зөвхөн уг 2 төслийг ашиглалтад оруулахад 10 гаруй жилийн хугацаа шаардагдахаар байгаа нь стратегийн 2 гол бүтээгдэхүүн болох газрын тос, цахилгаан эрчим хүчний импортын хараат байдал хэвээр байх эрсдэлийг нөхцөлдүүлж байна.

2. Газрын тосны бүтээгдэхүүний хувьд 2024 оны байдлаар Монгол Улс өнгөрсөн хугацаанд нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон, 1.9 тэрбум ам.доллар зарцуулсан бол Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, хугацаанд нь ашиглалтад оруулснаар зөвхөн нэг жилд 1.5 сая тонн газрын тосны

бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1.0 тэрбум ам.долларын борлуулалтын орлого олж, энэ хэмжээгээр валютын гадагшлах урсгалыг бууруулах боломж бүрдэх юм.

3.2024 оны байдлаар баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 80 хувийг импортоор нийлүүлж байгаа бөгөөд үүнд жилд дунджаар 17.5 тэрбум төгрөг зарцуулж байгаа бол Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл амжилттай хэрэгжиж, усан цахилгаан станц ашиглалтад орсноор 366.0 сая киловатт/цаг эрчим хүч үйлдвэрлэж, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангах төдийгүй жилд дунджаар 30.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой болно.

Үүнээс гадна хэрэгжиж байгаа бусад 70 төслийн санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдлийг гэрээний хугацаанд багтаан санхүүжүүлэхэд 2026 онд 2.5 их наяд төгрөг 2027-2028 онуудад 2.6 их наяд төгрөг ашиглах шаардлагатай байгаа боловч тухайн жилийн төсөвт ашиглалтын хэмжээ хангалттай түвшинд тусгагдахгүй байгаагаас үүдэн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, хөгжлийн бодлогын зорилтуудыг хангаж чадахгүйд хүрч байна.

4.Тандан судалгааны тайланд тусгаснаар өмнөх онуудад 3 төсөл тутмын 1 нь хугацаа сунгаж зардлын хэтрэлт бий болж байсан бол цаашид бүх төслүүдэд хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт бий болох эрсдэлтэй байна. Улмаар төслийн хэрэгжилт удаашрах, дээр дурдсан төслүүдэд хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт бий болох тусам Засгийн газраас тухайн зээлийн үйлчилгээний төлбөрт төлөх зардлын дүнг нэмэгдүүлж байна.

5.Гадаад зээлийн санхүүжилтийг хөгжлийн түнштэй байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хугацаанд ашиглахгүй, үр дүнг гаргахгүй, гэрээний үүргийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа нь зээл олгогч талын итгэлд сөргөөр нөлөөлж, цаашдын хамтын ажиллагааг сааруулах, шинэ гадаад эх үүсвэр татах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

6.Монгол Улс 2024 оны 7 дугаар сард Дэлхийн банкны ангиллаар "дундаас дээгүүр орлоготой" орны ангилалд шилжсэнтэй холбогдуулан нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр хумигдаж эхэлсэн. Үүний улмаас цаашид шинээр авах зээлийн нөхцөл арилжааны нөхцөлтэй зээл болж өөрчлөгдөж байна. Иймд, Газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн харьцангуй хямд эх үүсвэрийг цаг алдалгүй ашиглаж, хугацаанд нь төслийг бүрэн ашиглалтад оруулах нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна.

7.Гадаад зээлийн төслүүдийн санхүүжилтийг гадаад валютаар авдаг бөгөөд валютын хэлбэлзэл, ханшийн өөрчлөлт нь санхүүгийн төлөвлөлтийг хүндрүүлж байна.

Тандан судалгаагаар эх үүсвэртэй зардлыг төсөвт хэрхэн тусгах, төсөвт дарамт үзүүлэхгүй байдлаар гадаад зээллэгийн нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй эх үүсвэртэй төслүүдийг зардлын хязгаарт хязгаарлагдахгүйгээр ашиглах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, стратегийн ач холбогдох бүхий төслүүдийг ашиглалтад оруулахад одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байх тул хууль тогтоомжоор боломжит эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна.

Иймд, Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол, үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулиар тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн зорилго нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, Нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулна. Хуулийн төсөл нь 10 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан харилцааг зохицуулна. Үүнд:

1.Хуулийн төсөлд хуулийн хамрах хүрээг тодотгож, дээр дурдсан төслүүдийн зөвхөн гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулж, тэдгээр төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, зарцуулалт зэрэг бусад асуудлын хувьд холбогдох хууль тогтоомжид заасныг баримтлан хэрэгжүүлэхийг зохицуулна.

Энэ хуулийн үйлчлэлд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд хамаарах талаар тусгана.

2.Тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ нь дээрх 3 төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох ба ийнхүү нэмэгдсэн дүн нь нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хязгаарт хамаарахгүй болохыг хуулиар зохицуулна.

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын

нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар заасан бөгөөд дээрх 3 төслүүдийн санхүүжилтийн ашиглалтаар нэмэгдэх зардлаар тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал хэтэрч болох зохицуулалтыг авч үзнэ.

4.Түүнчлэн, тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болохыг хуульчилна.

5.Хуулийн төсөлд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэн нөхцөлд Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэгт заасныг хамааруулж үзэхгүй байхаар тусгана.

6.Түүнчлэн, Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн гадаад зээллэгийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй байх талаар тусгана.

7.Мөн, энэхүү хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж буй талаар Засгийн газраас УИХ-д тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн хамт тайлагнах тухай зохицуулалтыг хуулийн төсөлд авч үзнэ.

8.Түүнчлэн, дээрх төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, төслийн ашиглалттай холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол, ил тод хүргэх талаар тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд дараах ач холбогдол, эерэг үр дагаврыг бий болгоно. Үүнд:

1.Монгол Улсын стратегийн гол бүтээгдэхүүний импортын хэт хамаарал буурч, валютын гадагшлах урсгал эрс багасаж, дотоодын хэрэглээг өөрсдийн бүтээгдэхүүнээр хангаж, ингэснээр эдийн засгийн хөгжлийг дэмжиж, 2300 гаруй ажлын байр нэмэгдэнэ;

2.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогуудад тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангана;

3.Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1.0 тэрбум ам.долларын орлого олох бөгөөд дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангаж, импортын хараат байдлыг бууруулахаас гадна шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ;

4.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц ашиглалтад орсноор баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангаж 17.5 тэрбум төгрөгийг дотооддоо үлдээнэ. Түүнчлэн, жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангаснаар ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчний төлбөрийг 17.5 тэрбум төгрөгөөр хэмнэнэ

5.“Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит нөлөө үзүүлэхээс гадна 10.000 – 12.000 айл, өрхийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх замаар иргэдийг орон сууцжуулах төрийн бодлого хэрэгжих боломж бүрдэнэ;

6.Улсын Их Хурлаас соёрхон баталсан зээлийн гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна;

7.Гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт үүсэх эрсдэлээс сэргийлнэ;

8.Хуулийн төсөлд мега төсөл болох 2 төслийн зохицуулалт хийгдэж байгаа боловч зохицуулалтын үр нөлөөгөөр бусад төслүүдийн хэрэгжилт сайжирч, төсөвт тусгагдах гадаад зээллэгийн ашиглалтад орон зай гарснаар үлдсэн төслүүдийг хугацаанд нь ашиглалтад оруулах боломж бүрдэнэ;

9.Гадаад зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлснээр хэлэлцээрийн шатанд хүлээгдэж байгаа нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүд хэрэгжиж эхлэх нөхцөл бүрдэнэ;

10.Гадаад зээллэгийн санхүүжилтийг богино хугацаанд үр дүнтэй ашиглах нь төсөвт учруулах дарамтыг багасгах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, улмаар олон улсын хэмжээнд Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлж, зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Гадаад зээллэгийн санхүүжилт нь Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн томоохон эх үүсвэр бөгөөд үндэсний хэмжээний дэд бүтцийн сүлжээг бүрдүүлэх, нийгмийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх, төсвийн богино хугацааны ачааллыг бууруулах, гадаад зээллэгийн төслүүдийг дагаж салбаруудад шинэ техник технологи, инновац, ноу хау нэвтрүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бий болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон

холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Уг хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй болно.

----o0o----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн товч танилцуулгыг доорх байдлаар бэлтгэлээ.

1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих хууль нь 2021 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 3.1-д “Энэ хуулиар Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах болон түүхий тос дамжуулах хоолойн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийг барьж, ашиглалтад оруулах, үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.” гэж заасан байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 1 дүгээр хавсралтын 3.6.2-т “Дорноговь аймгийн Алтанширээт суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна” гэж, 3.2.22-т “Ховд аймгийн Ховд гол дээр эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина” гэж тус тус заасан.

3. Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газарт олгосон. Үүний дагуу Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ”-г санхүүжүүлэх зориулалтаар 500.0 (таван зуу) хүртэлх сая ам.долларын нийслэлийн гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд 2024 онд багтаан арилжаалахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид зөвшөөрсөн байна.

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл ... боловсруулахад хийнэ.” гэж, мөн тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, эсхүл хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаанд гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх асуудлыг анхдагч хуулиар зохицуулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

¹ Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

Ийнхүү дээр дурдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Тандан судалгааны тайланд тусгагдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн уг хуулийн төслийг боловсруулав.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлыг өмнө нь хуулиар зохицуулж байгаагүй бөгөөд анхдагч хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зардлын хэмжээ болон тэнцвэржүүлсэн тэнцэлд гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн зардлыг тусгаж тооцдог. Тус хуулийн нөлөөгөөр импортыг орлож, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх чадамжтай, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий томоохон төслүүдийг санхүүжүүлэхэд хуульд заасан төсвийн зардал, тэнцлийн хязгаарыг давахаар байгаа нь тухайн төслүүдийг зогсонги байдалд оруулж байна.

Иймд, гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх тодорхой төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхээр хуулийн төслийг боловсруулж байна.

Гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд болох нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээг нэмэгдүүлж болохоор хуулийн төсөлд тусгалаа.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар заасан бөгөөд дээрх төслүүдийн санхүүжилтийн ашиглалтаар нэмэгдэх зардлаар тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал хэтэрч болохоор тусгасан болно.

Хуулийн төсөлд тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох тухай зохицуулалтыг авч үзэв.

Түүнчлэн, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т орон нутгийн төсвийг алдалгүй баталж, хэрэгжүүлэхээр заасан. Иймд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтаар нэмэгдэх зардлыг алдагдалд тооцохгүй байхаар хуулийн төсөлд тус тус тусгалаа.

Хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлалд үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Н.Алтаншагай, О.Амгаланбаатар, Ч.Анар, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Р.Батболд, Ж.Батжаргал, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Б.Бейсен, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Д.Ганбат, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Х.Жангабыл,

Д.Жаргалсайхан, Б.Заяабал, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, О.Номинчимэг, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Л.Соронзонболд, Ц.Туваан, Ч.Ундром, Г.Уянгахишиг, Дав.Цогтбаатар, Д.Энхтуяа, М.Энхцэцэг нар санаачлан боловсруулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилсан тандан судалгаа, олон улсын харьцуулсан судалгааг тойм байдлаар гүйцэтгэж, хуулийн төслийн бүрдүүлбэрт оруулсан болно. Мөн түүнчлэн, хуулийн төслийн зардлын тооцооны болон үр нөлөөний үнэлгээний тайланг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хөндлөнгийн багаар хийлгүүлж, зөвлөмжийг тусган ажиллалаа.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт цахим хуудсанд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр байршуулсан бөгөөд олон нийтээс хуулийн төсөлд санал ирүүлээгүй болно.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн зохицуулалтад хамаарах мэдээллийг агуулсан дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэв. Уг хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй тул дагалдсан хуулийн төслүүд байхгүй болно.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны дагуу уг хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл боловсруулсан болно.

Хуулийн төсөл нь 10 зүйлтэй бөгөөд уг хуулийн зорилго нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийн зохицуулалтуудыг зүйл тус бүрээр доор дэлгэрэнгүй тайлбарлав.

- Хуулийн төсөлд хуулийн хамрах хүрээг тодотгож, гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх уг хуульд заасан төслүүдийн зөвхөн гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулж, үүнээс бусад асуудлын хувьд холбогдох хууль тогтоомжид заасныг баримтлах талаар зохицуулна.
- Уг хуулийн үйлчлэлд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд хамаарах болохыг хуулийн төсөлд тодорхойлон тусгана.
- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр¹ батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлага болон

¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
12 дугаар зүйл. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл

12.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана:

12.1.1. дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ;

нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ² нь дээр дурдсан нийт төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болохоор тусгасан бөгөөд ийнхүү нэмэгдсэн дүн нь энд дурдсан нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хязгаарт хамаарахгүй байхаар зохицуулав. Энэхүү зүйл нь гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хуулийн төслийн голлох ач холбогдолтой зохицуулалт бөгөөд ийнхүү зохицуулснаар дээрх 3 том мега төслүүдийн зээлийн ашиглалт нэмэгдэж, төслийг тогтоосон хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

- Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар заасан бөгөөд дээрх төслүүдийн санхүүжилтийн ашиглалтаар нэмэгдэх зардлаар тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал хэтэрч болохоор хуулийн төслийн 5 дугаар зүйлд заав.
- Түүнчлэн, хуулийн төслийн 6 дугаар зүйлд тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно гэж тусгав. Жил бүрийн төсвийн тухай хуулийг батлахдаа Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг тогтоодог бөгөөд өнгөрсөн хугацаанд тогтоож байсан дээд хэмжээнүүд нь эдгээр төслүүдийг тухайн жилд хэрэгжүүлэхэд огтхон ч хүрэлцдэггүй байсан. Иймд, ийнхүү хуулиар төслүүдийн зээллэгийн ашиглалтад тогтоодог хязгаарыг тооцохгүйгээр ашиглалтын эх үүсвэрээ төсөл бүрд төлөвлөсөн хуваарийн дагуу зарцуулах нь төсөл хугацаандаа, үр дүнтэй хэрэгжих боломжийг бүрдүүлнэ гэж хууль санаачлагчаас үзсэн.
- Хуулийн төслийн 7 дугаар зүйлд уг хуулийн 3.3-т заасан Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэн нөхцөлд Төсвийн тухай хуулийн 57.2³ дахь хэсэг хамааруулж үзэхгүй талаар зохицуулав. Орон нутгийн төсөв буюу нийслэлийн төсвийг батлахад Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн ашиглалтын зардлын дүнг оролцуулан тооцох нь нийслэлийн төсвийг алдагдалтай

12.1.2.хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

12.1.3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ;

12.1.4.нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ;

12.1.5.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл;

12.1.6.нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ;

12.1.7.нэгдсэн төсвийн суурь тэнцэл;

12.1.8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ;

12.1.9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ.

² **19 дүгээр зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам**

19.9.Энэ хуульд заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.

³ **Төсвийн тухай хууль**

57 дугаар зүйл.Орон нутгийн төсөв

57.2.Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

батлагдсан гэж үзэхгүй гэсэн агуулгаар энэ зохицуулалтыг оруулсан бөгөөд нийслэлийн хувьд энэхүү том төслийн бондын эх үүсвэрийг төлөвлөсөн хугацаанд, бүрэн дүүрэн ашиглах хууль зүйн боломж бүрдэх юм.

- Хуулийн төслийн 8 дугаар зүйлд “Засгийн газар нь энэ хуулийн хэрэгжилтийн талаарх тайланг тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн хамтаар хагас жил тутам Улсын Их Хуралд хүргүүлнэ” гэж заасан. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай энэхүү хуулиар Засгийн газар болон төсөл хэрэгжүүлэгчид тухайн төслүүдийн зээллэгийн ашиглалтын хэмжээг нэмэгдүүлж, хуулиар тусгайлан боломж олгож буй тул үүнтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж буй талаар, мөн тухайн жилд төслүүдийн төсвийн гүйцэтгэл ямар дүнтэй байгааг хамтад нь тайлагнаж байхыг хуулиар ийнхүү үүрэгжүүлсэн.
- Түүнчлэн, Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, төслийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжид нууцад хамааруулснаас бусад мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд тогтмол, ил тод мэдээлж байхаар хуулийн төслийн 9 дүгээр зүйлд тусгасан.
- Хуулийн төслийн төгсгөлийн зүйлд хууль батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх болохыг заав.

Хуулийн төсөлд тусгасан нэр томъёоны тайлбарын талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4⁴-т заасны дагуу хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн бичвэрт “гадаад зээллэг” гэсэн нэр томъёог оруулсан бөгөөд уг зүйлийн доор Тайлбар оруулж ““Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-т тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.” гэж зааснаар уг хуулийн үйлчлэлд хамаарах төслүүд нь гадаад зээлийн болон гадаад үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжих төслүүд болохыг тодорхойлж, ойлгомжтой болгосон.

---o0o---

⁴ Хууль тогтоомжийн тухай хууль

30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.4.Хуулийн төсөлд дараах тохиолдолд нэр томъёоны тайлбар хийнэ:

30.4.1.нэр томъёо нь олон утгатай бол;

30.4.2.нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол;

30.4.3.шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол.

Төсөл: 2025.05.05

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Тайлбар: “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах ба энд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй доор дурдсан төсөл хамаарна:

3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

3.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл;

3.3. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

4 дүгээр зүйл. Тухайн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нийт төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал, түүний зардлын өсөлтөөр нэмэгдэж болох бөгөөд ийнхүү нэмэгдсэн дүн нь дээрх хязгаарт үл хамаарна.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нийт төслийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэнээр тухайн жилийн нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтэрч болно.

6 дугаар зүйл.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтын зардал нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нийт төслийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

7 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 57.3 дахь хэсэгт заасан урьд оны үлдэгдлээс санхүүжих зардал, энэ хуулийн 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэн нөхцөлд Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэг хамаарахгүй.

8 дугаар зүйл.Засгийн газар нь энэ хуулийн хэрэгжилтийн талаарх тайланг тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн хамтаар хагас жил тутам Улсын Их Хуралд хүргүүлнэ.

9 дүгээр зүйл.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн хэрэгжилт, санхүүжилт, төслийн ашиглалттай холбоотой мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд тогтмол, ил тод мэдээлнэ.

Гарын үсэг

**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ,
ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ АНХДАГЧ
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАНДАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

ТОВЧИЛСОН ҮГ.....	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛ.....	4
УДИРТГАЛ.....	5
НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	6
1.1. Гадаад зээллэг ба өнөөгийн нөхцөл байдал.....	6
1.1.1. Гадаад зээллэг ба өнөөгийн нөхцөл байдал	6
1.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт болон мега төслүүдийн хэрэгжилт	7
1.1.3. Гадаад зээллэгийн хууль, эрх зүйн орчин.....	8
1.1.4. Гадаад зээллэгийн төслүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол	12
1.1.5. Тулгамдаж буй асуудлууд	13
1.1.6. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд	18
1.1.7. Асуудал үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.....	20
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО.....	22
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ	23
3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:	23
3.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх:.....	23
3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах:	24
3.4. Төрөөс шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэх:	24
3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	24
3.6. Захиргааны шийдвэр гаргах:	25
3.7. Хууль тогтоомжийн зохицуулалт хийх (шинэ хууль батлах)	25
ДӨРӨВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ.....	27
ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	28
5.1.Гадаад улсын хууль тогтоомж	28
ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	31
Хавсралт	33

ТОВЧИЛСОН ҮГ

АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан цахилгаан станц
ОХУ	Оросын холбооны улс
ХТБ	Хөгжлийн түнш байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, ТЕЗ-аар /тэрбум төгрөг/	14
Хүснэгт 2.	Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, ХТБ-аар /тэрбум төгрөг/	15
Хүснэгт 3.	Хувилбарын харьцуулалт	25

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан хуулийн шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын хүрээнд **ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН¹ АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ** анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг боловсруулсан болно.

Тандан судлах ажиллагааг гүйцэтгэхдээ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын дараах үе шатуудыг илүү тоймлон хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 1) Асуудалд дүн шинжилгээ хийх;
- 2) Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
- 3) Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, харьцуулан судлах;
- 4) Хуулийн зохицуулалтын үр нөлөөг ерөнхийд нь тандан судлах;
- 5) Олон улсын харьцуулсан судалгаа хийх;
- 6) Зөвлөмж боловсруулах.

¹ Тайлбар: “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

1.1. Гадаад зээллэг ба өнөөгийн нөхцөл байдал

1.1.1. Гадаад зээллэг ба өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улс 1990 онд эдийн засгийн тогтолцоог сольж, ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагт шилжсэн түүхэн шилжилт нь улсын эдийн засгийн бүтэц, удирдлагын тогтолцоог цогцоор нь өөрчлөх шаардлагыг бий болгож, үүний үр дүнд эдийн засгийн хүндрэл, сорилттой тулгарсан. Ийм нөхцөл байдалд гадаадын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын эдийн засгийг сэргээх, шинэ нөхцөлд дасан зохицуулах, бүтцийн шинэчлэл хийхэд онцгой чухал, голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр хангалтгүй, төсөв санхүүгийн хомсдол гүнзгий байсан тул гадаадын зээл, тусламж нь нэн шаардлагатай болсон.

Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улс олон улсын санхүүгийн болон хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэж, тэдгээрээс нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг татах үйл ажиллагааг эхлүүлсэн.

1990-ээд оны эхэн үе нь эдийн засгийн шилжилтийн хамгийн хүнд үе байсан бөгөөд энэ хугацаанд буюу 1990–1999 онуудад Монгол Улс олон улсын байгууллагууд болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд нийтдээ 1.3 тэрбум ам.долларын гадаад нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийг авч, эдгээр зээлүүд нь эдийн засгийн бүтцийн шинэчлэл, төрийн байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлт, банк, санхүүгийн салбарын шинэ тогтолцоог бий болгох, чадавхжуулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь дэд бүтцийг бий болгох, эдийн засгийн уналтын сөрөг үр дагаврыг бууруулах, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх зэрэг олон чиглэлд зарцуулагдсан байна.

Үүний дараа 2000 оноос эхлэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт харьцангуй тогтворжиж, шинэ дэд бүтэц бий болгох, үндэсний эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаад зээл нь өмнөх арван жилтэй харьцуулахад илүү хөрөнгө оруулалтын шинжтэй, урт хугацааны хөгжлийн бодлогын чиглэлд чиглэх болсон бөгөөд энэ үед нийтдээ 1.5 тэрбум ам.долларын зээлийг дулааны цахилгаан станцын шинэчлэл, авто болон төмөр зам барих, орон нутгийн хөгжил, орон сууц, нийтийн аж ахуй болон агаарын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор авч ашигласан.

Харин 2010-аад оны эхэн үеэс эхлэн Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой болж, гадаад зээлийн нөхцөл хосолмол хэлбэртэй буюу хөнгөлөлттэй болон арилжааны нөхцөл хосолсон хэлбэрт шилжиж, сүүлийн 15 жилийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотын хүн амын өсөлт, төвлөрөл нэмэгдсэнтэй уялдан хотын суурьшлын бүсийг тэлэх, зам тээвэр, инженерийн дэд бүтэц, нийтийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд эдгээр төсөл, хөтөлбөрүүд нь улсын төсвийн шууд хөрөнгө оруулалтаар санхүүжих боломжгүй, өндөр өртөг бүхий хөрөнгө оруулалтын төсөл байсан тул гадаадын хөнгөлөлттэй зээлийг үндсэн эх үүсвэр болгон ашигласан.

Ийнхүү Монгол Улсын Засгийн газар 1991–2024 онуудад хөгжлийн түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас нийтдээ 6.6 тэрбум ам.доллар буюу 21.7 их наяд төгрөгийн гадаад зээлийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор авч ашигласан бөгөөд энэ хүрээнд нийт 211 төсөл хэрэгжүүлсний 139 нь амжилттай хэрэгжиж дууссан, харин 72 зээлийн төсөл нь одоогоор хэрэгжилтийн шатандаа үргэлжлэн хэрэгжиж байна.

Өнөөдрийн байдлаар тухай төслүүдийн нийт ашиглаагүй үлдэгдэл 12.6 их наяд төгрөг байна. Үүнээс 46 хувь буюу 5.7 их наяд төгрөг нь стратегийн ач холбогдол бүхий томоохон бүтээн байгуулалтын төслүүд болох Газрын тос боловсруулах үйлдвэр барих болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслүүдэд ноогдож байна. Түүнчлэн хэрэгжилтийн шатанд байгаа бусад 70 төслийн 26 нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бөгөөд эдгээр төслүүд нийт ашиглагдаагүй үлдэгдлийн 17 хувийн эзэлж байна. Харин үлдсэн 44 төслийн хүрээнд нийт 4.6 их наяд төгрөгийн зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл байна.

1.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт болон мега төслүүдийн хэрэгжилт

Хэрэгжиж буй гадаад төслүүдийг төсөвт өртгийн хэмжээгээр ангилан үзвэл 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 төсөл, 100.0-500.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл, 50.0-100.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, 50.0 тэрбум төгрөг хүртэл төсөвт өртөгтэй 13 төсөл тус тус хэрэгжиж байна. Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөгтэй нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл бөгөөд нийт 5.8 их наяд төгрөгийн өртөгтэй байна. Харин хамгийн бага төсөвт өртөгтэй нь 24.9 тэрбум төгрөгийн өртөгтэй Монгол-Германы хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль төсөл байна. Монгол Улсын Их Хурлаас 2025 оны төсвийн тухай хуулиар гадаад зээлийн ашиглалтад нийт 1.5 их наяд төгрөгийг баталсан бөгөөд үүнээс 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 төслийн зээлийн ашиглах хэмжээ нь нийт батлагдсан зээлийн ашиглалтын 36 хувийг, үлдсэн 66 төслийн ашиглалт 64 хувийг тус тус эзэлж байна.

1.1.3. Гадаад зээллэгийн хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газрын шугамаар хөгжлийн түнш, гадаад орон, олон улсын байгууллагаас авч хэрэгжүүлдэг гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалт, санхүүжилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг бөгөөд төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг² тооцогддог. Түүнчлэн, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалт, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн Төсвийн бүтцийн талаарх 4 дүгээр бүлэгт зааснаар татварын бус орлогод хамаарах замаар төсвийн орлогыг бүрдүүлдэг³.

Хууль, эрх зүйн орчин

- Гадаадын зээл, тусламжийн асуудлыг хамтад нь 2003 оны Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулиар^[1] зохицуулж байсан бөгөөд 2015 онд Өрийн удирдлагын тухай хуулийг^[2] баталснаар уг хууль хүчингүй болсон.
- Гадаад зээл, тусламжийн хууль, эрх зүйн орчин, зохицуулалтын хувьд гадаад зээл нь өр үүсгэдэг, эргэн төлөгдөх шинж чанартай байдаг тул Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Олон улсын гэрээний тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Хуулиуд

- Төсвийн тухай хууль (2011);
- Өрийн удирдлагын тухай хууль (2015);
- Олон улсын гэрээний тухай хууль (2016);
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020);
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай (2024);
- Иргэний хууль (2002);
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015);
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2023);
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль (2006); болон
- Холбогдох бусад.

Хуульчилсан актууд

² Төсвийн тухай хууль, 6.3.4. төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

Төсвийн тухай хууль, 23 дугаар зүйл. Төсвийн орлого, 23.10. Энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан тусламжийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна.

³ Төсвийн тухай хууль, 23 дугаар зүйл. Төсвийн орлого, 23.3. Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/30 дугаар тушаал “Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа, ажил, үйлчилгээг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах журам”;
- Сангийн сайдын 2017 оны 164 дүгээр тушаал “Гадаад зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн албан орчуулгыг хянан баталгаажуулах тухай”;
- Гадаад харилцааны сайдын 2017 оны А/73 дугаар тушаал “Монгол Улсын олон улсын гэрээний орчуулга хийх, хянан баталгаажуулах журам”;
- Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Нэмэлтээр – Өрийн удирдлагын тухай хуулийн 25.9-д⁴ заасны дагуу Сангийн яамнаас боловсруулж буй “Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам” – энэхүү журам батлагдаагүй байгаа.
- Холбогдох бусад.

Хууль зүйн үндэслэл

Дэд бүтцийн мега төслүүдийн хэрэгжилтэд хамаарах зохицуулалтыг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.
2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих хууль нь 2021 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 3.1-д “Энэ хуулиар Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах болон түүхий тос дамжуулах хоолойн

⁴ Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэгт “Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам”-ыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална

үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийг барьж, ашиглалтад оруулах, үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.” гэж заасан ба энэхүү хуулийн дагуу “Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг 2021 онд Засгийн газрын 241 тоот тогтоолоор баталсан байдаг.

3. Улсын Их Хурлаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-тэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 1.0 тэрбум ам.долларын, 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 700.0 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг тус тус хуулиар соёрхон баталсан. Энэ хүрээнд Засгийн газраас 2017 онд “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тухай” 59 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолын 1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэхээр тогтсугай.” гэж заасан байна.
4. Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталж, тус хэлэлцээрийн хүрээнд “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг 2024 оны 11 дүгээр сард байгуулаад байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдэд дээр дурдсан дэд бүтцийн мега төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2 дугаар хавсралтын 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна” гэж, 4.2.36-д “Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна” гэж, 3.2-т “Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн орон байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, 3.2.3-т “Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ.”;
2. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал”-ын 1 дүгээр хавсралтын 3.2.4.3-т “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана” гэж, 3.2.4.2-т “Эрчим хүчний дотоодын гол эх

үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана” гэж;

3. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3 дугаар хавсралт дахь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 8-д “Эрчим хүчний шинэ эх үүсвэр барих төслүүд /...Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц,/” гэж, 11-д Газрын тос боловсруулах төслүүд /Газрын тосны нөөц хайгуулын төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, дагалдах барилга байгууламжийн төсөл/” гэж;
4. Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 1 дүгээр хавсралтын 3.6.2-т “Дорноговь аймгийн Алтанширээт суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна” гэж, 3.2.22-т “Ховд аймгийн Ховд гол дээр эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина” гэж;
5. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1 дүгээр хавсралтад 14 мега төслийн жагсаалтын 3-т “Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.” гэж, мөн жагсаалтын 12-т “Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна.” гэж;
6. Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 2 дугаар хавсралт дахь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.4.3.8-д “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг үргэлжлүүлэх.”, 1.7.2.1-д “Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих.” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ”-г санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газарт олгосон.

Үүний дагуу Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээ”-г санхүүжүүлэх зориулалтаар 500.0 (таван зуу) хүртэлх сая ам.долларын

нийслэлийн гадаад үнэт цаасыг олон улсын зах зээлд 2024 онд багтаан арилжаалахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид зөвшөөрсөн байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд нь Монгол Улсын хөгжлийн томоохон дэд бүтцийн мега төслүүдэд тооцогдох бөгөөд эдгээр төслийн үйл ажиллагааг гэрээ, хэлэлцээрт заасан гадаад зээл, үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлдэг болно.

Гэвч жил бүрийн төсвийн хуулийн зээллэгийн ашиглалтын хязгаараас шалтгаалан эдгээр төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа юм. Энэ байдал нь томоохон дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт удаашрах, хугацааны болон бүтээмжийн алдагдал хүлээхэд хүргэхээс гадна энэ хэрээр зардлын өсөлтийг нэмэгдүүлж байдаг дуталтай. Хамгийн гол нь тухайн төслийн үр дүнгээр хэрэгжиж, хангагдах байсан улс орны хөгжлийн томоохон зорилтууд биелэгдэхгүй, ард иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй хугацаа сунжрах асуудлууд үргэлжилсээр байгаа юм.

Иймд, дээр дурдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах, дэд бүтцийн мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх буюу гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

1.1.4. Гадаад зээллэгийн төслүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол

Монгол Улс 2021–2024 оны хугацаанд нийт 7.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоход нийтдээ 6.2 тэрбум ам.доллар зарцуулсан бөгөөд энэ нь жилд дунджаар 1.9 сая тонн бүтээгдэхүүн импортолж, 1.6 тэрбум ам.долларын валютын урсгал гадагш чиглэж байгааг харуулж байна. 2024 оны гүйцэтгэлийн үзүүлэлтээр нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолж, 1.9 тэрбум ам.доллар зарцуулсан нь 2021 онтой харьцуулахад импортын тоо хэмжээ 25 хувиар, импортын үнэ өртөг 54 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид дотоодын хэрэглээ тогтмол нэмэгдэхийн хэрээр газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ болон валютын гадагшлах урсгал нэмэгдэх хандлагатай байна.

Энэ нөхцөлд Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах нь эдийн засгийн хувьд зайлшгүй шаардлагатай болоод байна. Тус үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж

эхэлснээр жилд дунджаар 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ойролцоогоор 1.0 тэрбум ам.долларын борлуулалтын орлого олох боломжтой юм. Үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг 2024 оны импортын түвшинтэй харьцуулан тооцоход, дотоодын газрын тосны бүтээгдэхүүний нийт хэрэглээний 50–60 орчим хувийг хангах боломжтой бөгөөд энэ нь жилд дунджаар 1.0 тэрбум ам.долларын валютын урсгалыг дотоодод үлдээх үр нөлөөтэй юм.

Мөн баруун бүсийн эрчим хүчний систем нь хэрэглээнийхээ 80 гаруй хувийг гадаадын эх үүсвэрээс, тэр дундаа 74 хувийг ОХУ-аас, 2 хувийг БНХАУ-аас импортоор хангаж байгаа нь эрчим хүчний хамаарал өндөр байгааг илтгэж байна. Тухайлбал, 2023 онд баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ 264.87 сая кВт.ц-д хүрч, өмнөх оноос 11.2%-иар өссөн ба энэ өсөлт нь цаашид жилд дунджаар 8–11 хувиар үргэлжлэх хандлагатай байна. Иймд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлснээр жилд 366 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэх, баруун бүсийг 2027 оноос эхлэн 100 хувь дотоодын эрчим хүчээр найдвартай хангах боломж бүрдэх юм. Энэхүү эх үүсвэрийн хүчин чадлаар 52,000 ахуйн хэрэглэгч, 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын өрхийг цахилгаанаар хангахын зэрэгцээ жил бүр 17.5 тэрбум төгрөгийн импортын зардлыг хэмнэх боломжтой. Түүнчлэн усны нөөцийг нэмэгдүүлж, цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, хүлэмжийн хийн ялгарлыг 330 мянган тонноор бууруулах байгаль орчинд үзүүлэх үр ашигтай.

Дээрх нөхцөл байдлууд нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдал, валютын урсгалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй учраас Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн УЦС зэрэг стратегийн бүтээн байгуулалтын төслүүдийг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх нь эдийн засгийн үр ашиг, тогтвортой хөгжлийн тулгуур нөхцөл болж байна. Иймд төслүүдийн барилга угсралтыг эрчимжүүлж, зээлийн хөрөнгийн үр ашигтай ашиглалтыг хангах, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.5. Тулгамдаж буй асуудлууд

Монгол Улсын Их Хурлаас баталсан сүүлийн таван жилийн Төсвийн тухай хуулиудаар улсын төсвийн нийт зарлагын дундаж хэмжээ 20.0 их наяд төгрөгөөр батлагдсан байна. Үүнээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдэд дунджаар 1.4 их наяд төгрөгийн зээлийн ашиглалт батлагдсан нь гэрээ байгуулсан нийт гадаад зээлийн үлдэгдлийн 14.8 хувийг л ашиглаж байгааг харуулж байна.

2025 оны Төсвийн тухай хуулиар гадаад зээлийн ашиглалтад 1.5 их наяд төгрөг баталсан нь төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн нийт 6.5 их наяд төгрөгийн саналын 24 хувийг хангаж байгаа бөгөөд энэ нь гадаад зээлийн нийт ашиглагдаагүй үлдэгдлийн 12 хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, гадаад зээлийн ашиглалтыг хангалттай түвшинд баталж чадахгүй байгаагаас шалтгаалан гурван төсөл тутмын нэг нь хугацаа сунгах шаардлагатай болж, төслийн дундаж хэрэгжилтийн хугацаа 1–2 жилээр уртсаж, таван жил болж байна.

Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчаар нь ангилж үзэхэд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Эрчим хүчний сайдын багцуудад хамгийн өндөр үлдэгдэлтэй байна. Үүний гол шалтгаан нь Засгийн газраас хэрэгжүүлж буй 14 мега төслийн хүрээнд багтсан Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслүүдийн зээлийн ашиглалтын үлдэгдэл харьцангуй өндөр байгаа явдал юм. Эдгээр хоёр томоохон төслийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхгүйгээр төслүүдийг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байна.

Хүснэгт 1: Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, ТЕЗ-аар /тэрбум төгрөг/

№	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСЛИЙН ТОО	ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДҮН	АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ	АШИГЛАЛ Т %
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	1	5,808.6	4,889.5	16%
2	Нийслэлийн Засаг дарга	14	2,250.9	1,651.9	27%
3	Эрчим хүчний сайд	8	2,214.8	1,574.1	29%
4	Зам, тээврийн сайд	6	1,831.6	1,120.9	39%
5	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	5	1,855.6	710.1	62%
6	Эрүүл мэндийн сайд	6	845.7	667.3	21%
7	Эдийн засаг, хөгжлийн сайд	4	576.9	570.9	1%
8	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга	4	503.2	402.9	20%

9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	4	428.7	299.1	30%
10	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	2	202.8	189.2	7%
11	Боловсролын сайд	5	480.6	152.5	68%
12	Шадар сайд /Онцгой байдлын асуудал эрхэлсэн/	2	135.6	87.8	35%
13	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	2	129.9	78.1	40%
14	Хууль зүй, дотоод хэргийн сайд	2	128.3	73.1	43%
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	1	50.8	49.6	2%
16	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2	244.2	35.2	86%
17	Сангийн сайд	2	132.9	28.7	78%
18	Орхон аймгийн Засаг дарга	2	55.9	23.2	58%
НИЙТ		72	17,877.3	12,604.2	29%

Мөн хөгжлийн түнш байгууллагуудаар ангилан авч үзвэл хамгийн их ашиглаагүй үлдэгдэлтэй төсөл нь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл байна. Түүнчлэн Азийн хөгжлийн банк (АХБ) Монгол Улсад хамгийн олон тооны төсөл хэрэгжүүлж байгаа хөгжлийн түнш бөгөөд түүний дараагаар БНСУ болон БНХАУ-ын санхүүжилттэй төслүүд ашиглагдаагүй үлдэгдлийн хэмжээгээр дараалж байна.

Хүснэгт 2: Гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, ХТБ-аар /тэрбум төгрөг/

№	ХӨГЖЛИЙН ТҮНШ	төсөл	ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДҮН	АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ	АШИГЛАЛТ %
1	БНЭУ	2	5,877.1	4,918.6	16%

2	АХБ	35	5,034.1	3,327.9	34%
3	БНСУ	7	1,901.7	1,139.4	40%
4	БНХАУ	4	1,892.3	1,121.5	41%
5	Дэлхийн банк	6	1,198.7	861.8	28%
6	ЕСБХБ	6	1,024.2	653	36%
7	БНФУ	3	351.8	258.1	27%
8	ЕХОБ	2	178.1	144.6	19%
9	ХНБГУ	2	97.8	86.7	11%
10	Япон	1	164.9	37.1	78%
11	Австри	2	62.3	32.5	48%
12	Польш	2	94.4	22.9	76%
НИЙТ		72	17,877.3	12,604.2	29%

Иймд, Монгол Улсад гадаад зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх, хөрөнгийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулалтыг хангах, валютын урсгалыг дотооддоо шингээх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтуудыг хугацаанд нь дуусгах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Тодруулбал, төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналын дөнгөж 24 хувь нь төсвөөр батлагдаж байгаа, нийт гэрээ байгуулсан зээлийн дөнгөж 14.8 хувь нь л жил бүрийн төсвөөр ашиглагдаж буй, ашиглагдаагүй үлдэгдэл жил ирэх тусам хуримтлагдаж буй, санхүүжилтийн хэмжээ хангалтгүйгээс шалтгаалан төслийн хэрэгжилтийн хугацаа уртсаж, зардал өсөх, зорилтот үр дүнгээ бүрэн хангаж чадахгүй болох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж байна. Цаашлаад стратегийн бүтээн байгуулалт болох Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц зэрэг мега төслүүд санхүүжилтийн хомстлоос шалтгаалан хугацаа алдаж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэлд эрсдэл үүсгэх нөхцөл бүрдэж байна.

Гадаад зээллэгийн ашиглалттай холбоотой дараах асуудлууд практикт тулгамдаж байна. Үүнд:

1. Гадаад төслийн зээлийн нийт ашиглагдаагүй үлдэгдэл одоогийн байдлаар 12.6 их наяд төгрөг буюу үүний 53 хувь буюу 6.7 их наяд төгрөг нь Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих мега төслүүдийн санхүүжилт байна. Гадаад төслийн зээлийн ашиглалтыг 2025 оны түвшнээр буюу дунджаар 1.5 их наяд төгрөг байхаар тооцвол зөвхөн уг 2 төслийг ашиглалтад оруулахад 10 гаруй жилийн хугацаа шаардагдахаар байгаа нь стратегийн 2 гол бүтээгдэхүүн болох газрын тос, цахилгаан эрчим хүчний импортын хараат байдал хэвээр байх эрсдэлийг нөхцөлдүүлж байна.
2. Газрын тосны бүтээгдэхүүний хувьд 2024 оны байдлаар Монгол Улс өнгөрсөн хугацаанд нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон, 1.9 тэрбум ам.доллар зарцуулсан бол Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, хугацаанд нь ашиглалтад оруулснаар зөвхөн нэг жилд 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1.0 тэрбум ам.долларын борлуулалтын орлого олж, энэ хэмжээгээр валютын гадагшлах урсгалыг бууруулах боломж бүрдэх юм.
3. 2024 оны байдлаар баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 80 хувийг импортоор нийлүүлж байгаа бөгөөд үүнд жилд дунджаар 17.5 тэрбум төгрөг зарцуулж байгаа бол Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл амжилттай хэрэгжиж, усан цахилгаан станц ашиглалтад орсноор 366.0 сая киловатт/цаг эрчим хүч үйлдвэрлэж, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангах төдийгүй жилд дунджаар 30.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой болно.
4. Үүнээс гадна хэрэгжиж байгаа бусад 70 төслийн санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдлийг гэрээний хугацаанд багтаан санхүүжүүлэхэд 2026 онд 2.5 их наяд төгрөг 2027-2028 онуудад 2.6 их наяд төгрөг ашиглах шаардлагатай байгаа боловч тухайн жилийн төсөвт ашиглалтын хэмжээ хангалттай түвшинд тусгагдахгүй байгаагаас үүдэн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, хөгжлийн бодлогын зорилтуудыг хангаж чадахгүйд хүрч байна.
5. Тандан судалгааны тайланд тусгаснаар өмнөх онуудад 3 төсөл тутмын 1 нь хугацаа сунгаж зардлын хэтрэлт бий болж байсан бол цаашид бүх төслүүдэд хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт бий болох эрсдэлтэй байна.
6. Улмаар төслийн хэрэгжилт удаашрах, дээр дурдсан төслүүдэд хугацааны хоцрогдол, зардлын хэтрэлт бий болох тусам Засгийн газраас тухайн зээлийн үйлчилгээний төлбөрт төлөх зардлын дүнг нэмэгдүүлж байна.
7. Гадаад зээлийн санхүүжилтийг хөгжлийн түнштэй байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хугацаанд ашиглахгүй, үр дүнг гаргахгүй, гэрээний үүргийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа нь зээл олгогч талын итгэлд сөргөөр нөлөөлж, цаашдын хамтын ажиллагааг сааруулах, шинэ гадаад эх үүсвэр татах боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

8. Монгол Улс 2024 оны 7 дугаар сард Дэлхийн банкны ангиллаар "дундаас дээгүүр орлоготой" орны ангилалд шилжсэнтэй холбогдуулан нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр хумигдаж эхэлсэн. Үүний улмаас цаашид шинээр авах зээлийн нөхцөл арилжааны нөхцөлтэй зээл болж өөрчлөгдөж байна. Иймд, Газрын тос боловсруулах үйлдвэр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн харьцангуй хямд эх үүсвэрийг цаг алдалгүй ашиглаж, хугацаанд нь төслийг бүрэн ашиглалтад оруулах нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна.
9. Гадаад зээлийн төслүүдийн санхүүжилтийг гадаад валютаар авдаг бөгөөд валютын хэлбэлзэл, ханшийн өөрчлөлт нь санхүүгийн төлөвлөлтийг хүндрүүлж байна.

Иймээс гадаад зээлээр санхүүжих төслүүдийн хэрэгжилтийг хурдасгах, хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох, дотоодын чадамжийг дайчлан эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх эрх зүйн шинэчлэл шаардлагатай бөгөөд үүний хүрээнд гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.6. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Төрөөс нийтийн хэрэгцээг хангах зориулалттай, нийтээрээ ашиглах эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, эрчим хүч, дулаан хангамж, зам, дэд бүтцийн барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалт буюу улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламжийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжүүлдэг.

Нийтийн хэрэгцээг хангах зориулалттай, нийтээрээ ашиглах шаардлагаар дулааны станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд бүтцийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усны байгууламж, худаг, үерийн далан, усан сан, авто зам, гүүрний барилга байгууламж, нисэх буудал, зорчигч тээврийн авто үйлчилгээний төв, гудамж, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, услалтын систем, агропарк зэрэг бүтээн байгуулалтыг төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжаар хийдэг.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогуудад тусгагдсан зорилт арга хэмжээнүүд бөгөөд эрчим хүчний дотоодын гол хэрэглээ болох цахилгаан эрчим хүч, газрын тосны бүтээгдэхүүний импортыг орлох, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах, агаар, орчны бохирдлыг бууруулах, орон сууцжуулах томоохон үр нөлөөтэйгөөс гадна байгаль орчинд сөрөг нөлөө багатай, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж,

дотоодын эх үүсвэрээр цахилгаан эрчим хүчний баруун бүсийн хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх юм.

Мөн Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1.0 тэрбум ам.долларын орлого олох бөгөөд дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангаж, импортын хараат байдлыг бууруулахаас гадна шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл амжилттай хэрэгжиж, усан цахилгаан станц ашиглалтад орсноор 366.0 сая киловатт/цаг эрчим хүч үйлдвэрлэж, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангах төдийгүй жилд дунджаар 30.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой. үүнчлэн, жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангаснаар ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчний төлбөрийг 17.5 тэрбум төгрөгөөр хэмнэнэ

“Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит нөлөө үзүүлэхээс гадна 10.000 – 12.000 айл, өрхийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх замаар иргэдийг орон сууцжуулах төрийн бодлого хэрэгжих боломж бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх 16 багц үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хуульчилсан. Тодруулбал, гадаад зээлээр хэрэгжүүлдэг төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, иргэнийхээ өмнө төрийн хүлээсэн хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ гүйцэтгэхэд чиглэгддэг. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд нь энэхүү төрийн үүргийг хангахад чиглэсэн төслүүд бөгөөд эдгээр төслийн үр нөлөөнд Монгол Улсын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол шууд болон шууд бус байдлаар хөндөгдөнө.

Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхгүй, төслийн хэрэгжилтийг удаашруулах, санхүүжилтийг төлөвлөсөн хугацаанд бүрэн ашиглахгүй байх, эсхүл үр дүн муутай хэрэгжүүлэх нь нийт иргэдийн төрөөс нийгмийн суурь дэд бүтцээр

хангуулах эрх, төрөөс үйлчилгээ авах эрх, ашиг сонирхол хөндөгдөх буюу сөргөөр нөлөөлөх болно.

1.1.7. Асуудал үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл

Монгол Улсад сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг мега төсөл, хөрөнгө оруулалт болон дэд бүтцийн төсөлд зарцуулах чиглэл баримталж байгааг олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагаас эергээр дүгнэсэн болно.

Гэвч мега төслүүд, дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

1. Төслийн хэрэгжилт удаан;
2. Төслийн төсөвт өртөг нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэдэг;
3. Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй;
4. Төслийн гадаад зээллэгийн хөрөнгийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байх.

Дэд бүтцийн томоохон төслүүдийн хэрэгжилт удаан, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ордоггүй нь дараах шалтгаан, нөхцөлтэй байна. Үүнд:

- Газрын асуудал шийдэгдээгүй, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөл батлуулаагүй төслийг төсөвт тусгадаг;
- Төлөвлөлтөд эрэмбэ баримталдаггүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөдөггүй, төлөвлөлтийг салбарын бодлоготой уялдуулдаггүй;
- Төлөвлөлтийг зохицуулдаг хууль, эрх зүйн орчин нэгдмэл бус, ойлгомжгүй, төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд хяналтын тогтолцоо сул;
- Зураг төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, техникийн нөхцөл, зургийн даалгавар, ТЭЗҮ боловсруулалт, зураг төслийн магадлал муу, чанаргүй хийгддэг, ТЭЗҮ-д тавигдах шаардлагыг тогтоосон стандарт байхгүй;
- Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулдаг.

Төслийн төсөвт өртөг нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэдэг нь дараах шалтгаан, нөхцөлтэй байна. Үүнд:

- Санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр жилийн төсвийн хуулиар хязгаартай байдгийн улмаас санхүүжилтийг бүрэн ашиглах боломжгүй болдог.
- Олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй болдог.

- Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явцад ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдалтай;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажил чанаргүй, магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маяггүй;
- Нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгадаггүй, үүнээс захиалагч, гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү гардаг;
- Гэрээ, хэлэлцээрээр батлагдсан гадаад зээл, үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн жилд батлагдсан гадаад төслийн зээлийн дээд хэмжээнээс шалтгаалан төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх эрсдэл үүсгэдэг;

Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй байгаа нь “ерөнхийдөө” төслийн хэрэгжилт удаан, төслийн төсөвт өртөг нэмэгддэг байдалтай шууд хамааралтай, үндсэн шалтгаан, нөхцөлийг бүрдүүлдэг.

Төслийн гадаад зээллэгийн хөрөнгийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй буйн үндсэн шалтгаан нь нэгж төслийн хувьд тухайн жилийн төсвийн хуулиар гадаад төслийн зээлийн зардлын дээд хязгаарыг төлөвлөсөн зээлийн санхүүжилтийн хэмжээнээс багаар баталдагт оршдог бөгөөд үүний улмаас гэрээ, хэлэлцээрээр батлагдсан гадаад зээл, үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүйд хүрдэг.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хууль зүйн зохицуулалт, эрх зүйн боломж байхгүй байгаа нь дээрх асуудлуудын хувьд бас нэг үндсэн шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байна.

Мега төслүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хууль тогтоомжийг бий болгох шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлого, зорилтын хүрээнд гадаад зээллэгийн хөрөнгөөр стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан 14 мега төслийн жагсаалтад багтсан “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”, “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”, мөн Нийслэлийн бүтээн байгуулалтын хүрээнд хэрэгжүүлж буй “Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын төсөл” зэрэг төслүүд нь эдийн засгийн бие даасан байдал, эрчим хүч, шатахууны хараат байдлыг бууруулах, нийтийн дэд бүтцийг сайжруулах зэрэг олон талын үр өгөөжтэй, бодлогын тэргүүлэх ач холбогдолтой хөтөлбөрүүд юм.

Гэвч эдгээр төслүүдийг гадаад зээллэгийн хөрөнгөөр үр дүнтэй, хугацаанд нь хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр тогтоогддог гадаад зээлийн ашиглалтын дээд хязгаар нь төсөлд шаардлагатай санхүүжилт хугацаанд олгогдохгүйд хүргэж, улмаар төслийн үйл ажиллагаа удаашрах, хэрэгжилт хоцрох эрсдэл үүсгэж, зарим тохиолдолд төслийн зардал нэмэгдэх, хугацаа хэтрэх, үр өгөөж нь буурах хүндрэлийг бий болгох эрсдэлтэй байна

Иймд, дээрх стратегийн ач холбогдолтой төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэх талаарх зохицуулалтыг хуулиар тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аргачлалд заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойллоо:

Ерөнхий зорилт:

Төсвийн тухай хуулиар жил бүр тогтоогддог гадаад зээлийн ашиглалтын хязгаарлалтад хамрагдахгүй байх тусгай нөхцөлийг хуульчилж, стратегийн ач холбогдол бүхий дээрх төслүүдийг гадаад зээлийн эх үүсвэрээр тогтвортой, саадгүй санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх. Ингэснээр төслийн хэрэгжилтийг шуурхай болгож, зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдал, эрчим хүч, шатахууны хараат байдлыг бууруулах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх юм.

Хууль тогтоомжийн тухай хууль болон Аргачлалын дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг бүрэн хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд гадаад зээллэгийн эх үүсвэрээр саадгүй, тогтвортой санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

3.1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төсвийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд гадаад зээлийн (зээллэг) ашиглалтыг шаардлагатай хэмжээнд хүргэх боломж хязгаарлагдмал байна. Тодруулбал, жил бүр батлагддаг зээлийн ашиглалтын дээд хязгаар нь стратегийн ач холбогдолтой томоохон төслүүдийг тогтвортой, тасралтгүй санхүүжүүлэх нөхцөлийг хангаж чадахгүй байгаа нь эдгээр төслийн хэрэгжилтэд шууд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнээс үүдэн төслийн санхүүжилт хойшлох, гүйцэтгэл удаашрах, хугацаа хэтрэх, хүүгийн зардал нэмэгдэх, цаашлаад төслийн үр өгөөж буурах эрсдэл үүсэж байгаа тул энэ хувилбар нь бодит үр дүн авчрах боломжгүй гэж үзэж байна.

3.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх:

Гадаад зээлээр хэрэгжиж буй стратегийн төслүүдийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, төрийн бодлогын ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь тодорхой хэмжээнд нийгмийн ойлголтыг сайжруулах эерэг үр нөлөөтэй байж болох ч энэ нь эрх зүйн бодит зохицуулалт үүсгэхгүй. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн хязгаарлалтыг даван туулах, гадаад зээллэгийг шаардлагатай хэмжээнд тогтвортой ашиглах эрх зүйн үндэс бүрдүүлэхэд хангалтгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэх бодит гарц болж чадахгүй юм. Иймд энэхүү хувилбар нь асуудлын мөн чанарыг шийдвэрлэх чадамжгүй, бодит үр дүн өгөх боломжгүй гэж дүгнэж байна.

3.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах:

Зах зээлийн эдийн засгийн механизмуудыг ашиглах нь тодорхой үр өгөөж, нөлөөллийг тооцоолох боломжгүй байдаг. Хэдийгээр татвар, урамшууллын механизм ашиглах боломжтой ч эдгээр нь төслийн хэрэгжилтэд тодорхой үр дүн авчрахгүй. Тандан судалгаагаар тавьж буй зорилгод нийцэхгүй бөгөөд үр дүн нь бага.

3.4. Төрөөс шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэх:

Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Газрын тос боловсруулах үйлдвэр, Сэлбэ дэд төвд түшиглэсэн орон сууцжуулах төсөл зэрэг нь өртөг өндөртэй, олон улсын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжиж буй томоохон бүтээн байгуулалтууд юм.

Эдгээр төслүүдийг улсын төсвөөс шууд санхүүжүүлэх нь Монгол Улсын төсвийн өнөөгийн нөхцөл байдал, санхүүгийн багтаамжийг харгалзан үзвэл бодитоор хэрэгжих боломжгүй хувилбар юм. Үүнээс гадна, ийм шийдвэр нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулна.

Иймд төрөөс шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хувилбар нь бодит нөхцөлд тохиромжгүй, үр дүнгүйд тооцогдож байна.

3.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Газрын тос боловсруулах үйлдвэр, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын төслүүд нь Засгийн газрын оролцоо, баталгаатай хэрэгжиж буй үндэсний хэмжээний стратегийн төслүүд юм.

Эдгээр төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар нь олон улсын зээлийн хэлэлцээр байгуулж, тухайн гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэлийн баталгаа, үнэт цаасны баталгаа хүлээсэн байдаг.

Ийм нөхцөлд уг үүргүүдийг төрийн бус байгууллага эсвэл хувийн хэвшилд шилжүүлэх нь хуулийн болон олон улсын гэрээний хүрээнд боломжгүй юм. Үүргийн хэрэгжилт, хариуцлагыг бүрэн хангахын тулд Засгийн газар өөрөө эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Иймд энэ хувилбар нь бодит байдалд нийцэхгүй, үр дүнгүйд тооцогдоно.

3.6. Захиргааны шийдвэр гаргах:

Тусгай журмаар зохицуулах боломжтой ч эрх зүйн суурь зохицуулалт дутмаг байгаагаас энэ арга хэмжээ нь төслийн хэрэгжилтэд хязгаарлагдмал нөлөө үзүүлэх боломжтой. Захиргааны шийдвэрүүд нь төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэхгүй, үр дүн нь бага байх болно.

3.7. Хууль тогтоомжийн зохицуулалт хийх (шинэ хууль батлах)

Монгол Улсын стратегийн чухал ач холбогдол бүхий Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Газрын тос боловсруулах үйлдвэр, Сэлбэ дэд төвийн төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хуулийн дагуу жил бүрийн зээлийн ашиглалтын хязгаар нь төсөлд шаардлагатай санхүүжилтийг хугацаанд нь олгох боломжийг хязгаарлаж, улмаар төслийн үйл ажиллагаа удаашрах, хэрэгжилт хоцрох эрсдэл үүсгэж байна. Иймд эдгээр төслүүдийг тусгай зохицуулалтаар уг хязгаарлалтаас чөлөөлөх шинэ хууль батлах нь төсвийн дарамт үүсгэлгүйгээр зорилгод бүрэн нийцэх, хамгийн үр дүнтэй хувилбар юм.

Хүснэгт 3: Хувилбарын харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (Одоо байгаа зохицуулалтыг хэвээр үлдээх)	Өнөөгийн асуудал үргэлжилж, зорилгод хүрэх боломжгүй	Зардал гарахгүй боловч төслийн зогсонги байдал, хэрэгжилтийн саатал, хүүгийн зардал өсөх эрсдэлтэй	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн арга хэмжээ нь эрх зүйн зохицуулалтаар хүрэх зорилгод хүргэх боломжгүй	Сургалт, нэвтрүүлэг зэрэг нэмэлт зардал шаардагдах боловч шууд нөлөө үзүүлэхгүй	Үр дүнгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Татвар, урамшууллын механизм ашиглах боломжтой ч зорилгод нийцэхгүй	Тодорхой үр өгөөж, нөлөөллийг тооцоолох боломжгүй	Үр дүн бага
4	Төрөөс шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Төрөөс шууд санхүүжилт хийх нь төсвийн ачааллыг нэмэгдүүлж, зорилгод нийцэхгүй	Зардал өндөр, хэрэгжилт хангалтгүй	Үр дүнгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Засгийн газрын үүрэгт харьяалагдах асуудлыг төрийн бус болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх нь зохимжгүй	Зардал багатай боловч хууль зүйн хувьд нийцэлгүй	Үр дүнгүй

6	Захиргааны шийдвэр гаргах	Тусгай журмаар зохицуулах боломжтой ч эрх зүйн суурь зохицуулалт дутмаг	Хязгаарлагдмал нөлөөтэй	Үр дүн бага
7	Хууль тогтоомжийн зохицуулалт хийх (шинэ хууль батлах)	Төсвийн тухай хуулийн хязгаарлалтаас тодорхой нэр бүхий төслүүдийг чөлөөлөх эрх зүйн орчныг бий болгох боломжтой	Илүү зардал шаардахгүй, одоо байгаа чиг үүргийн хүрээнд хэрэгжих боломжтой	Үр дүнтэй

Зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг талын зардал-үр өгөөжийг хувилбар тус бүрээр харьцуулан үзэж, **"хууль тогтоомжийн төсөл боловсруулах"** хувилбар нь *"Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг бүрэн хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд гадаад зээллэгийн эх үүсвэрээр саадгүй, тогтвортой санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх"* зорилгыг хангаж чадах хамгийн сайн хувилбар болж байна гэж дүгнэлээ.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу тандан судалж, энэхүү тайланд хавсаргав. Үүнд:

- 1.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- 2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасны дагуу шалгуур асуултуудад хариулах замаар дүгнэв. (хавсралт 1) Хүний эрх, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлэхэд сөрөг, шууд нөлөөлөл илрээгүй болно. Харин эдийн засагт тодорхой хэмжээнд эерэг нөлөөлөл үзүүлэх магадлалтай гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ төрөөс хэрэгжүүлэн нийгмийн суурь хэрэгцээг хангах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, зээллэгийн санхүүжилтээр томоохон дэд бүтцийн болон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлдэг тул Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн зарчим, зохицуулалтад нийцнэ.

Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц , Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд нь Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн түнш оронтой байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгждэг бөгөөд Монгол Улс нь эдгээр төсөл, арга хэмжээг соёрхон баталсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх үүрэг амлалтыг түншлэгч орны өмнө хүлээсэн болно. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хууль нь энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй болно.

ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу Засгийн газрын гадаад зээллэгийн ашиглалтын олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийв.

5.1.Гадаад улсын хууль тогтоомж

Стратегийн ач холбогдолтой, олон жилийн хугацаанд хэрэгжих, өндөр өртөгтэй томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг тогтвортой, найдвартай санхүүжилтээр хангах нь төслийн үр ашиг, хэрэгжилтийн чанарт шууд нөлөөтэй. Гэвч Монгол Улсын Төсвийн тухай хуулиар жил бүрийн төсвийн хүрээнд гадаад зээлийн ашиглалтын дээд хязгаарыг нийт төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлтэй уялдуулан тогтоох нь эдгээр төслийг хугацаанд нь бүрэн санхүүжүүлэх боломжийг хязгаарлаж, улмаар төслийн эхлэл, үргэлжилсэн санхүүжилт хойшлох, зардал нэмэгдэх, хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах эрсдэл дагуулж байна. Тухайлбал, олон улсын байгууллагаас авсан зээлийг Монгол Улсын Засгийн газар тухайн төсөл, арга хэмжээний зорилтод нийцүүлэн төсөвт тусган санхүүжүүлэх хууль зүйн шаардлага нь зээлийн гүйцэтгэлд нөлөөлж, жил бүрийн төсвийн хэлэлцүүлгийн үр дүнгээс шууд хамааралтай болгож байна.

Энэ нөхцөл байдал нь төсөл хоцрох, төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, өртөг нэмэгдэх зэргээр эдийн засгийн бодлогын үр өгөөж буурах суурь шалтгаан болж буй тул стратегийн ач холбогдол бүхий төсөлд зориулсан гадаад зээлийн санхүүжилтийг тусгай нөхцөлөөр зохицуулах эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагыг төрийн бодлого, хууль тогтоомжийн судалгаагаар тогтоох үндэслэлтэй байна.

Сингапурын “Significant Infrastructure Government Loan Act 2021” хуулийн туршлага

Сингапур Улсын 2021 онд баталсан “Significant Infrastructure Government Loan Act” нь тухайн улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан стратегийн дэд бүтцийн төслүүдийг төсвийн жилийн хязгаарлалтаас ангид байдлаар, тусгай нөхцөлтэй зээлийн эх үүсвэрээр тогтвортой санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан нь олон улсын эрх зүйн зохицуулалтын онцлох жишээ болж байна. Энэхүү хуулиар стратегийн ач холбогдол бүхий төслийг тодорхой шалгуураар (доод тал нь 4 тэрбум сингапур долларын өртөг, 50 жилээс дээш ашиглалтын хугацаа, Засгийн газрын өмчид бүрэн хамаарах гэх мэт) ангилж, төсвийн жилийн хязгаарлалтаас ангид байлгах тусгай зохицуулалт хийсэн.

Уг хуульд зааснаар, дээрх шалгуурыг хангасан төслүүдийг парламентын баталгаа бүхий тусгай хөтөлбөрийн хүрээнд урт хугацааны зээлээр санхүүжүүлэх бөгөөд энэ нь төсвийн жил бүрийн хязгаарт нөлөөлөхгүйгээр хэрэгжих боломжтой байдаг. Энэхүү зохицуулалт нь нэг талаас төсвийн сахилга

бат, хариуцлагыг хадгалах, нөгөө талаас улс орны хөгжлийн тулгуур дэд бүтцийг тасралтгүй санхүүжүүлэх нөхцөлийг хангасан хосолмол механизм болжээ.

Монгол Улсын хувьд, стратегийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрүүд (жишээлбэл, усан цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчим хүчний сүлжээний өргөтгөл, дэд бүтцийн томоохон зангилаа зэрэг) нь ихэвчлэн урт хугацааны хэрэгжилттэй, өндөр өртөг шаарддаг, эдийн засгийн олон салбарт шууд болон шууд бусаар нөлөөлөх чадамжтай. Гэвч Төсвийн тухай хуулийн хүрээнд жил бүрийн улсын төсвөөр гадаад зээлийн ашиглалтын дээд хязгаарыг **нийт төсвийн тэнцэржүүлсэн тэнцэлтэй уялдуулан тогтоодог** нь тухайн төслийн хэрэгжилтийг удаашруулах, улмаар төслийн хэрэгжих хугацааг сунгах, төслийн хэрэгжих өртөгийг нэмэгдүүлэх зэрэг эрсдлийг бий болгож байна. Тухайлбал:

- Тухайн төсөлд шаардлагатай зээлийн санхүүжилт бүрэн тусгагдахгүй, **шаардлагатай хөрөнгө хойшлогдох, шат дараалсан санхүүжилт тасалдах;**
- **Гэрээний хэрэгжилт, ажлын явц хойшлох, бүтээн байгуулалт үргэлжилж чадахгүй болох;**
- **Өртөг нэмэгдэх, үр өгөөж буурах, олон улсын гэрээний үүрэг зөрчигдөх эрсдэл үүсч байна.**

Эдгээр нөхцөл байдал нь Сингапур Улсын хуульчилсан механизмаас шалтгаалан урьдчилан сэргийлэгдэж болох, ил тод, хариуцлагатай тогтолцоогоор шийдвэрлэгдэж байгааг харуулж байна. Иймд, дээрх эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсад өөрийн онцлогт уялдуулан хэрэглэх **боломж, шаардлага, үндэслэл** дараах байдлаар бүрдэж байна:

1. Эдийн засгийн хямрал, дэлхийн зах зээлийн савлагаанаас хамгаалах боломж

Монгол Улс гадаад эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай, ялангуяа байгалийн нөөцийн үнэ болон зах зээлийн эрэлтээс шалтгаалсан эдийн засгийн хямралтай тулгарч байна. Стратегийн төслүүдийг тусгай нөхцөлтэй урт хугацааны зээлээр санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалт нь эдийн засгийн савлагаа, зээлийн хүүгийн хэлбэлзэл зэрэг зовлонгоос хамгаалах механизм болж чадна. Үүний тусламжтайгаар стратегийн төслүүдийн санхүүжилт тогтвортой, урт хугацаанд шийдэгдэж, улсын хөгжлийн тулгуур дэд бүтцийн шаардлагыг хангах боломж бүрдэнэ.

2. Хэрэгжилтэд хяналт тавих, ил тод байдлыг хангах

Сингапурын хууль зүйн туршлагаас суралцан, стратегийн ач холбогдол бүхий төсөлд зориулсан гадаад зээллэгийн санхүүжилтийг тодорхой шалгуур, хязгаарлалтаар хянаж, төсвийн сахилга бат, ил тод байдал хангагдана. Хуульд тусгайлан нэрээр тусгаж өгснөөс бусад гадаад зээллэгийн төслийн санхүүжилтэд ямар нэгэн өөрчлөлт огт орохгүй бөгөөд Засгийн газрын 14 мега төслийн гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжих 2 төсөл үүнд орсноороо онцлог байна. Монгол

Улсад эдгээр төслийг хэрэгжүүлэхэд олон нийтийн, парламентын хяналтыг баталгаажуулах, хууль зүйн зохицуулалтыг зөвхөн санхүүгийн бус, хэрэгжилтийн чанарыг ч хянах боломжоор хангах шаардлага бий.

3. Олон улсын зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах

Сингапурын туршлагаас харвал, стратегийн ач холбогдолтой төсөлд зориулсан тусгай хууль баталснаар олон улсын гэрээний үүргийг биелүүлэх нөхцөлийг хөнгөвчилж олон улсын хөгжлийн түнш байгуулагуудын итгэлцлийг нэмэгдүүлэх ач холбогдолтойг харуулсан.

Иймд Сингапур Улсын дээрх хуульчилсан туршлагыг Монгол Улсад нутагшуулах, өөрийн хууль тогтоомжийн орчинд нийцүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн боломж байгаа бөгөөд энэ нь төсвийн санхүүгийн сахилга бат, парламентын хяналт, төсөл хөтөлбөрийн үр өгөөж, хэрэгжилтийн тогтвортой байдлыг зэрэг хангасан, олон талт ач холбогдолтой, оновчтой эрх зүйн шинэчлэл болох юм.

Дүгнэлт

- I. Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, төслийг бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
- II. Тандан судалгааны тайланд дурдсан тулгамдсан асуудлууд, нөхцөл байдлууд нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдал, валютын урсгалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй учраас Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн УЦС, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл зэрэг стратегийн бүтээн байгуулалтын төслүүдийг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх нь эдийн засгийн үр ашиг, тогтвортой хөгжлийн тулгуур нөхцөл болж байна. Иймд төслүүдийн барилга угсралтыг эрчимжүүлж, зээлийн хөрөнгийн үр ашигтай ашиглалтыг хангах, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- III. Монгол Улсад гадаад зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх, хөрөнгийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулалтыг хангах, валютын урсгалыг дотооддоо шингээх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтуудыг хугацаанд нь дуусгах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.
- IV. Иймд, хууль тогтоомжийн хэрэгжилт болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах, дэд бүтцийн мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх буюу **Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг** боловсруулж, батлуулах нь зүйтэй байна.

Зөвлөмж

Дээрх дүгнэлтийн дагуу Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахад хуулийн төсөлд дараах зохицуулалтуудыг тусгахыг зөвлөж байна. Үүнд:

1. Энэ хуулийн үйлчлэлд зөвхөн Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд хамаарах болохыг тодорхой заах;
2. Гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх дээрх төслүүдийн гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулж, бусад асуудлын хувьд холбогдох бусад хууль тогтоомжид заасныг баримтах ёстойг авч үзэх;
3. Хуулийн төсөлд дээр дурдсан төслүүдийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтаар нэмэгдэх зардал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1, 19.9-д заасан нэгдсэн төсвийн нийт зарлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээг нэмэгдүүлж болохыг зохицуулах;
4. Хуулийн төсөлд дээр дурдсан төслүүдийн гадаад зээллэгийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй болохыг зохицуулах;
5. Хуулийн төсөлд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн гадаад зээллэгийн санхүүжилтийн ашиглалтын зардал нэмэгдсэн нөхцөлд Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэгт заасныг хамааруулж үзэхгүй байхаар тусгах;
6. Түүнчлэн, Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн гадаад зээллэгийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй байхыг хуульд тодорхой заах;
7. Тус хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж буй талаар Засгийн газраас УИХ-д тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн хамт тайлагнах тухай зохицуулалтыг хуулийн төсөлд авч үзэх;
8. Түүнчлэн, дээрх төслүүдийн хэрэгжилт, санхүүжилт, төслийн ашиглалттай холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол, ил тод хүргэх талаар тусгах нь зүйтэй.

-----oOo-----

Хавсралт

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХҮНИЙ ЭРХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			Сөрөг нөлөө байхгүй.
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	1.2.Оролцоог хангах			Сөрөг нөлөө байхгүй.
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			Сөрөг нөлөө байхгүй.
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	<u>Тийм</u>	<u>Үгүй</u>	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<u>Тийм</u>	<u>Үгүй</u>	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүний эрхэд нөлөө үзүүлэх эрх агуулагчийн заалт тус хуулинд тусахгүй болно
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	<u>Үгүй</u>	

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үүрэг хүлээгчийг тодорхойлсон заалт байхгүй.
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн үйлчлэлд ямар нэгэн дотоодын ААН-ийн шударга өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд мега 3 төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд дотоод, гадаадын ААН-ийн үйл ажиллагааг дэмжинэ.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Гадаадын зээл, тусламжийг оновчтой ашиглах нөхцөл бүрдсэнээр гадаадын хөрөнгө оруулалтын итгэлийг нэмэгдүүлнэ.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Стратегийн дэд бүтцийн санхүүжилтийг тогтвортой хангах замаар эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зах зээл дээрх өрсөлдөөнт нөхцөлд нөлөөлөхгүй.

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хууль нь зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлахгүй, харин эдийн засгийн тогтвортой өсөлтөд чиглэсэн.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуульд зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлах ямар нэг заалт ороогүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	ААН-үүдэд нэмэлт тайлан, хяналтын үүрэг хүлээлгэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Засгийн газрын гадаад зээлийн үр ашигтай зохицуулалт бий болсноор хувийн хэвшлийн итгэлцэл өснө.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөөлөл байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	ААН-ийн үйл ажиллагаанд хязгаар тавихгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зөвхөн Засгийн газрын хүрээнд хэрэгжих зохицуулалт тул ААН-д нэмэлт үүрэг үүсгэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Хувийн өмчид шууд нөлөөлөх зохицуулалт байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хамаарахгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Стратегийн төсөлд техник, технологи, судалгаа нэвтрэх нөхцөл бүрдэнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Гадаад зээлээр технологийн шинэчлэл хийгдэх боломж нэмэгдэнэ.

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөө багатай
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Шууд хэрэглээний үнэ, өрхийн орлогод нөлөөлөхгүй боловч дэд бүтэц сайжрах замаар урт хугацаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төсөл хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдэж, шууд бус нөлөө эерэг гарна.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төслүүдийн хүрээнд бүтээн байгуулалт, үйлдвэрлэл нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төслийн ханган нийлүүлэлт, үйлчилгээний гинжин хэлхээнд ЖДҮ оролцох боломжтой.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гадаад зээлийн хэрэгжилт сайжирснаар хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Одоогийн бүтэц, зохион байгуулалтад үндэслэнэ.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Үгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Томоохон бүтээн байгуулалт, ажлын байр бий болно.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Төслийн хэрэгжилт сайжирснаар хөрөнгө оруулалтын нөхцөл сайжирч зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжинэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Шууд инфляц үүсгэх зохицуулалт хийгдээгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь гадаад зээл, тусламжийн талаарх олон улсын эрх

				зүйн хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулагдсан.
--	--	--	--	---

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд барилга, үйлчилгээний салбарт ажлын байр шинээр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хуулийн төсөл нь цомхотгол үүсгэх биш, харин бүтээмжтэй төсөл хэрэгжүүлэх зорилготой.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төсөл хэрэгжүүлэх явцад мэргэжлийн ажилчид, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн оролцоо нэмэгдэнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Насны ангиллаар шууд ялгаварлан үзэхгүй ч, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөлөөтэй байж болно.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Гадаад зээлийн төсөл хэрэгжүүлэгчдэд олон улсын стандарт шаардлага тавигддаг.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Олон улсын байгууллагын санхүүжилттэй төслүүд хөдөлмөрийн аюулгүй байдлын өндөр шалгуур тавьдаг.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Төслийн хэрэгжилтийн хүрээнд гэрээт харилцаа, ажлын нөхцөл, хөдөлмөрийн хяналт өөрчлөгдөж болзошгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Шинэ стандарт батлах биш, харин олон улсын

				стандартыг дагаж мөрдөхөд чиглэнэ.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Төсөл хэрэгжүүлэх явцад техник, технологийн шинэчлэл хийх шаардлага үүснэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь нийгмийн эмзэг бүлгийн оролцоог хангасан зарчимд тулгуурлана.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин эмзэг бүлгийг хамгаалах, тэдэнд чиглэсэн төсөл дэмжинэ.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн хэрэгжилт үндэсний түвшинд хамаарах тул гадаад иргэдэд чиглэсэн зохицуулалтгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Гадаад зээлийн үр ашигтай байдал, хариуцлагын тогтолцоо сайжирна.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төсөл хариуцсан албан хаагчид гүйцэтгэлийн үр дүн, тайлагналд илүү анхаарах шаардлагатай.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь эрх зүйн хамгаалалт сулруулахгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хууль нь улс төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд хамааралгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь эрүүл ахуйн хяналтыг дордуулахгүй

	хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд нөлөөлөхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд хамаарахгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хамааралгүй
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Үгүй
8. Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шууд хамааралгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шууд хамааралгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ	ХОЛБОГДОХ АСУУЛТ	ХАРИУЛТ		ТАЙЛБАР
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулж, хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэхэд чухал ач холбогдол үзүүлнэ.

2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хэрэгжилтийн цар хүрээнээс хамаарч өөр байж болох ч хууль нь өөрөө хэрэглээг нэмэгдүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Баруун бүсийн эрчим хүчний хараат байдлаас гарна.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх тул сөрөг нөлөө гарахгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хяналт тавигдах тул усны нөөцөд сөрөг нөлөөлөл гарахгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Ундны усны чанарт нөлөөлөхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	<u>Үгүй</u>	Үгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	<u>Үгүй</u>	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Усан цахилгаан станц нь сэргээгдэх нөөцийг ашиглах зорилготой.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	<u>Тийм</u>	Үгүй	Газрын тосны олборлолт, боловсруулалт нэмэгдэнэ.

**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ АНХДАГЧ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад¹ заасны дагуу **Гадаад зээллэгийн² ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн** зүйл, хэсэг, зохицуулалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д³ /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн. Үүнд:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Ганхуяг, Н.Алтаншагай, П.Сайнзориг нараас санаачлан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна. Энэхүү хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу холбогдох судалгаануудыг гүйцэтгэж, хуулийн төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийхдээ Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн 2025.05.02-нд боловсруулсан 1 дүгээр хувилбар дээр ажиллаж, үр нөлөөг тооцсон болно.

Хуулийн төсөлд тус хуулийн зорилго нь “Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилтыг хангах, нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд

¹ <https://legalinfo.mn/mn/detail/11119> 8.1.4.энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;

² **Тайлбар:** “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

³ <https://legalinfo.mn/mn/detail/11993>

түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад чиглэсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино” гэж заажээ.

Хуулийн төсөл нь 8 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгажээ.

**Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг
Нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл**

1 дүгээр зүйл. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Тайлбар: “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-т тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах ба энд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл хамаарах ба эдгээрээс өөр бусад төсөл, арга хэмжээ үүнд хамаарахгүй:

3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

3.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл;

3.3. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээнд болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд хамааруулахгүй.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн ашиглалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд тусгахгүй.

6 дугаар зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын дээд хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний ... хувиас хэтрэхгүй байна.

7 дугаар зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн зээлийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй.

8 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зохицуулалтаас сонгосон зүйл, хэсгийн бичвэр, боловсруулалт нь хуулийн үр дагаврын зохицуулалтын хувьд ойлгомжтой, зөрчилгүй бичигдсэн эсэх, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэх, түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Үнэлгээний ажлын энэ хэсэгт аргачлалд заасны дагуу Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг сонгох буюу тогтоож, өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлттэй үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тохируулан үнэлэхэд бэлтгэх юм. Хуулийн төсөл нь 8 зүйлтэй боловсруулагдсан тул үнэлэгдэх зүйл, хэсгийг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа буюу голлох ач холбогдолтой, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай зохицуулалтыг сонгосон болно.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн нийт зохицуулалт нь хуулийн төслийн үндсэн зорилгыг хангаж чадах эсэхийг үнэлэн тогтоох юм.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг судлан үзэхэд хууль санаачлагч нь дээр дурдсан багц зорилгыг дэвшүүлж тэдгээрийг хангах үүднээс хуулийн төслийг боловсруулсан байна. Аргачлалд заасны дагуу хуулийн төсөлд дээрх зорилгод хүрэх чиглэлээр тусгагдсан зүйл, хэсэг, заалтыг сонгон “зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэх юм.

Хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр бичигдсэн тул хуулийн төслөөс үнэлэх бүлэг, зүйл, хэсэг, заалтыг сонгож үнэлгээг хийх юм.

№	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилго	Зорилгыг хангахад чиглэгдсэн хуулийн төслийн зүйл, хэсэг
1	<u>Зорилго-1:</u> 2025 оны байдлаар Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан, хэрэгжилтийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа нийт 17.9 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаад зээлийн 72 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 5.3 их наяд төгрөг буюу 29.6 хувийг ашигласан, үлдсэн 12.6 их наяд төгрөг буюу 70.4 хувь нь одоогоор ашиглагдаагүй, үүнээс 2025 онд 1.5 их наяд төгрөгийг ашиглахаар 2025 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Эдгээр төслүүдийн 82 хувь нь 2025-2028 онд хэрэгжиж дуусахаар гэрээ, хэлэлцээртэй байгаа нь гэрээний хугацаанд санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлж, төслүүдийг ашиглалтад оруулах зайлшгүй шаардлагатай юм.	1 дүгээр зүйл.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино. 3 дугаар зүйл.Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл хамаарах ба эдгээрээс өөр бусад төсөл, арга хэмжээ үүнд хамаарахгүй: 3.1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл; 3.2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаа станц барих төсөл; 3.3.Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл. 4 дүгээр зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын

		хэмжээнд болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд хамааруулахгүй. 5 дугаар зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн ашиглалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд тусгахгүй. 7 дугаар зүйл. Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн зээлийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй.
2	<u>Зорилго-2:</u> Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг санхүүжүүлэх талаарх зохицуулалтыг хуулиар тодорхойлж, тогтоох шаардлагатай байна.	2 дугаар зүйл. Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах ба энд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна. 3 дугаар зүйл. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл хамаарах ба эдгээрээс өөр бусад төсөл, арга хэмжээ үүнд хамаарахгүй: 3.1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл; 3.2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаа станц барих төсөл; 3.3.Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн зохицуулалтаас дараах зохицуулалтын ойлгомжтой байдлыг үнэлнэ. Үүнд:

➤ Хуулийн төслийн 1 дүгээр зүйл:

1 дүгээр зүйл.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

➤ Хуулийн төслийн 4 дүгээр зүйл:

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээнд болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд хамааруулахгүй.

➤ Хуулийн төслийн 8 дугаар зүйл:

8 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хуулийн төслийг бусад хуультай нийцсэн, уялдсан эсэхийг шалгах тул бүхэлд нь шалгахаар сонгов.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

№	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
3	Харилцан уялдаа	Харилцан уялдаатай эсэхийг шалгаж, үнэлэх

4.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Зорилго 1. 2025 оны байдлаар Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан, хэрэгжилтийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа нийт 17.9 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаад зээлийн 72 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 5.3 их наяд төгрөг буюу 29.6 хувийг ашигласан, үлдсэн 12.6 их наяд төгрөг буюу 70.4 хувь нь одоогоор ашиглагдаагүй, үүнээс 2025 онд 1.5 их наяд төгрөгийг ашиглахаар 2025 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Эдгээр төслүүдийн 82 хувь нь 2025-2028 онд хэрэгжиж дуусахаар гэрээ, хэлэлцээртэй байгаа нь гэрээний хугацаанд санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлж, төслүүдийг ашиглалтад оруулах зайлшгүй шаардлагатай юм.

1 дүгээр зүйл.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

3 дугаар зүйл.Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл хамаарах ба эдгээрээс өөр бусад төсөл, арга хэмжээ үүнд хамаарахгүй:

3.1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

3.2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаа станц барих төсөл;

3.3.Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээнд болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд хамааруулахгүй.

5 дугаар зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн ашиглалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд тусгахгүй.

7 дугаар зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн зээлийн ашиглалтыг тухайн жилийн батлагдсан Төсвийн тухай хуульд заасан Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээний хязгаарт оруулж тооцохгүй.

Хуулийн төслийн үзэл баримтлалаар гадаад зээл болон үнэт цаасны эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлж,

төслүүдийг ашиглалтад оруулах зайлшгүй шаардлагатай байгааг тодорхойлсон бөгөөд энэхүү хэрэгцээ, шаардлагад үндэслэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна. Тандан судалгааны тайлангийн зохицуулалтын хувилбарын үнэлгээгээр анхдагч хууль байх нь тохиромжтой болохыг тогтоосон бөгөөд хуулийн төслийн хувьд одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хувилбар нь тохиромжгүй, гадаад зээллэгт хамаарах 3 төсөлд зориулан бие даасан хуулиар гадаад зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна. Зорилго 1-д тусгасан асуудлыг Хуулийн төслийн 1, 3, 4, 5 болон 7 дугаар зүйлд тусгасан зохицуулалтууд шийдвэрлэж, уг зорилго хангагдахаар тусгасан гэж үзэв.

Зорилго 2. Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, Засгийн газрын өрийн баталгаагаар баталгаажсан импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийг санхүүжүүлэх талаарх зохицуулалтыг хуулиар тодорхойлж, тогтоох шаардлагатай байна.

2 дугаар зүйл. Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах ба энд зааснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

3 дугаар зүйл. Энэ хуулийн үйлчлэлд гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй дараах төсөл хамаарах ба эдгээрээс өөр бусад төсөл, арга хэмжээ үүнд хамаарахгүй:

3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл;

3.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл;

3.3. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан гадаад зээллэгийн 3 төслийн талаарх Зорилго 2-т заасан асуудал нь Хуулийн төслийн 2 болон 3 дугаар зүйлд заасан зохицуулалтаар шийдвэрлэгдэх буй уг зорилго биелэгдэхээр боловсруулагдсан гэж үзлээ. Тодруулбал, Хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж төслүүдийг 3.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, 3.2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаа станц барих төсөл болон 3.3. Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл гэж тодорхой заасан байна.

4.2. Хуулийн төслийн ойлгомжтой байдлын үнэлгээ:

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг хуулийн төсөлд нийтэд нь шалгаж үнэлсэн бөгөөд үүнээс гадна тодорхой зүйлүүдийг сонгож, ойлгомжтой байдлаар боловсруулсан эсэхийг шалгав.

Уг үнэлгээний тайлангийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслөөс сонгож авсан зүйл, хэсэг, заалтын ойлгомжтой байдлыг үнэлбэл:

➤ Хуулийн төслийн 1 дүгээр зүйл:

1 дүгээр зүйл.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан, үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг холбогдох гэрээ, хэлэлцээрээр тогтоосон хугацаанд ашиглаж, бүрэн ашиглалтад оруулахад зориулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Үнэлгээ:

1/Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн бичвэрт “гадаад зээллэг” гэсэн нэр томъёог оруулсан бөгөөд уг зүйлийн доор Тайлбар оруулж “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-т тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.” гэж зааснаар уг хуулийн үйлчлэлд хамаарах төслүүд нь гадаад зээлийн болон гадаад үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжих төслүүд болохыг тодорхойлж, ойлгомжтой болгосон байна.

2/Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн бичвэрт “мега төсөл” гэсэн шинэ нэр томъёог хэрэглэсэн байх бөгөөд мега төслийн талаар тодорхойлсон хууль тогтоомж байхгүй тул энэ талаар уг хуулийн төсөлд, эсхүл холбогдох бусад хуульд олон улсын нэр томъёоны тодорхойлолт, эсхүл тайлбар оруулах нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 4 дүгээр зүйл:**

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 3.1 – 3.3-т заасан төслийн гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтын зардлын хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4, 12.1.5-д заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээнд болон нэгдсэн төвийн тэнцвэржүүлсэн тэнцэлд хамааруулахгүй.

Үнэлгээ: Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн бичвэрт тухайн хууль дотроо болон бусад хуулийн заалтыг эшилсэн зохицуулалтыг тусгасан байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн бичвэрийг найруулгын хувьд ойлгомжтой, тодорхой болгон сайжруулах үүднээс 5 дугаар зүйлийн бичвэртэй нэгтгэж болохоор байна.

➤ **Хуулийн төслийн 8 дугаар зүйл:**

8 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хугацаа дуусгавар болох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

Үнэлгээ: Хуулийн төслийн 8 дугаар зүйлд хууль хэрэгжиж эхлэх болон нийт үйлчлэх хугацааг зохицуулсан нь хөгжлийн санхүүжилтийн мега буюу томоохон төслүүд нь урт хугацаанд үйлчилдэг ба тухайн төслийн гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд дуусах тул энэ хуульд заасан гадаад зээллэгийн ашиглалтыг нэмэгдүүлэх эрх зүйн боломжийг ямар хугацаанд хэрэглэхийг хугацааны хувьд ойлгомжтой, тодорхой зохицуулалт гэж үнэллээ.

Түүнчлэн Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад

тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Бүрэн нийцсэн байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн бичвэр уг шаардлагыг хангасан байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төслийн хүрээнд холбогдох бусад хуулийн заалтыг давхардуулалгүй, эш татсан зохицуулалт тусгасан байх тул энэ шаардлагыг хангасан байна.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Хуулийн төсөлд хууль хэрэгжих, хүчинтэй үйлчлэх хугацааг тусгасан бөгөөд холбогдох шаардлагыг хангасан байна. Уг хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй гэсэн байна.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй гэсэн байна.

29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Энэ талаарх зохицуулалт байхгүй тул энэ шаардлагыг хангасан гэж үзлээ.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан нь хуулиар тавигдсан шаардлага болон ойлгомжтой байх шалгуур үзүүлэлтийг хангасан байна гэж дүгнэлээ.

4.3.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо болон Монгол Улсын бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэхийг Аргачлалд заасан шалгуур асуултуудын хүрээнд шалгаж тогтоолоо.

№	Асуулт	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгодоо нийцсэн байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төсөлд “Хууль тогтоомж” гэсэн хэсэг зохицуулагдаагүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зохицуулалтаар бусад хууль хооронд аливаа давхардал үүсэх зохицуулалт агуулаагүй байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Нийцсэн байна.

7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Нийцсэн байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төслийн зохицуулалтаар төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй байна.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Ийм зохицуулалт тусгагдаагүй байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Ийм зохицуулалт тусгагдаагүй байна.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Ийм зохицуулалт тусгагдаагүй байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөлд ийм зохицуулалт шаардлагагүй бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг зөрчихүйц зохицуулалт тусгагдаагүй байна.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
15	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Ийм зохицуулалт тусгагдаагүй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу тооцож хуулийн төслийг нийтэд нь ерөнхий байдлаар үнэллээ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан нь тавигдаж буй шаардлагыг хангасан байна.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь ойлгомжтой, логик дараалалтайгаар томъёологдсон байна. Хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

Аргачлалд заасан дор дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг гаргав:

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр

Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилгуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг бүрэн тусгасан байна.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалтуудыг нэр томъёо, найруулга, хэл зүй, агуулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар томъёолж, хуулийн зорилгыг хангахаар бичвэрийг боловсруулсан байна.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт болон шударга бус өрсөлдөөн, авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй байна.

Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн бичвэрт “мега төсөл” гэсэн шинэ нэр томъёог хэрэглэсэн байх бөгөөд мега төслийн талаар тодорхойлсон хууль тогтоомж байхгүй тул энэ талаар уг хуулийн төсөлд, эсхүл холбогдох бусад хуульд олон улсын нэр томъёоны тодорхойлолт, эсхүл тайлбар оруулах нь зүйтэй байна.
2. Хуулийн төсөл нь цаашид урт хугацаанд үргэлжлэх тул хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж төслүүд буюу 3.1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, 3.2.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаа станц барих төсөл болон 3.3.Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүд дээр өөр төсөл нэмэгдүүлж оруулахгүйн тулд зохицуулалтын хаалт хийх үүднээс хуульд ийнхүү төсөл нэмэгдүүлэхийг хориглосон заалт нэмж тусгахыг санал болгож байна.

-----oOo-----

ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу **Гадаад зээллэгийн¹ ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төсөл** /цаашид “Хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон тухайн аргачлалд заасан зардлууд гарах эсэхийг шинжлэн судлав.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төслийг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байна. “Аргачлал”-ын 1.5-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн зардал болон төрийн байгууллага буюу төсөвт үүсэх зардлыг тооцов.

Хуулийн төсөлд иргэнд болон хуулийн этгээдэд шууд зардал үүсгэсэн заалт байхгүй, иргэн болон хуулийн этгээдэд хамааралтай нэмж гүйцэтгэх үүргийн талаар тусгаагүй байна. Иймд, хуулийн төсөл батлагдсанаар шууд үүсэх зардал байхгүй болно.

Хуулийн төслийн үйлчлэлд хамаарч буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл болон Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн үйл ажиллагааг гэрээ, хэлэлцээрт заасан гадаад зээл, үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлдэг болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл батлагдсанаар гадаад зээллэгийн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлж буй хэдий ч тэдгээр төслийн үйл ажиллагааг батлагдсан олон улсын зээлийн гэрээ, хэлэлцээрийн дагуу олгогдсон санхүүжилтийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй тул улсын төсөвт сөрөг нөлөө, ачаалал үзүүлэхгүй юм.

Түүнчлэн, хуулийн төсөл батлагдсанаар шинээр төрийн байгууллагын нэгж байгуулах, эсхүл төрийн албаны бүтэц, орон тоонд нэмэлт оруулах, мөн холбогдох бусад зардал нэмэгдэх шаардлага үүсэхээргүй байна. Иймд, төрийн байгууллагын зардал гарахгүй гэж тооцов.

Дүгнэлт: Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт дарамт учруулахгүй, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхгүй, улсын төсөвт шинээр нэмэлт зардал бий болохгүй болно.

¹ **Тайлбар:** “Гадаад зээллэг” гэдэгт Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.2, 4.1.15-д тус тус заасан гадаад зээл, үнэт цаас зэрэг хөгжлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг ойлгоно.



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,

23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,

Улаанбаатар хот, 17100

Утас: (976-11) 32 39 77, 32 71 99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.12.04 № 01/7946

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.АЛТАНШАГАЙ ТАНАА

Та болон Улсын Их Хурлын нэр бүхий 39 гишүүний санаачлан боловсруулсан Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Тус хууль батлагдсанаар Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан гадаад зээл, тусламжийн 116 төсөл шуурхай хэрэгжих нөхцөл бүрдэхийн сацуу нийт зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 14.5 их наяд төгрөгийг бүрэн ашиглах боломж бүрдэж, зээлийн ашиглалт, үр ашиг сайжирна гэж үзэж байгаа тул хуулийн төслийг дэмжиж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

X.Нямбаатар

Х.НЯМБААТАР

1725140932



2022-2023

ಸಹಕಾರಿ : ೬೨೬ - ೨೨ - ೩೩ ನೇ ೬೬ : ೩೩ ೩೬ ನೆ

2022.09.02
مفتی

9/9/2022

[illegible][illegible]

A. H. B. B.

[illegible]

1725080738



УИХ-ын гишүүн
Хассуурийн ГАНХУЯГ

ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН
АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ